

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН”-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



М.ХУЛАН

УЛААНБААТАР ХОТ, СХД 20-Р ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
“УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 8299331/

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧ:
“М-СИ-ЭС ПРОПЕРТИ” ХХК-ИЙН
ХАБЭАБО-НЫ АЛБАНЫ ДАРГА
“М-СИ-ЭС ПРОПЕРТИ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АЖИЛТАН



Т.ТҮВШИНТӨР

М.ХУЛАН

Улаанбаатар хот, 2022 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
1.1 Төслийн тодорхойлолт	7
1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил	8
1.3 Төслийн үндсэн зорилго	8
2. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
3. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ	11
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
4.1 Байгаль орчны мэдлэг олгох сургалт зохион байгуулах	12
4.2 УДБҮ-ийн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагалдах төлөвлөгөөнүүд	14
4.3 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	15
4.4 Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	17
4.5 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	20
4.6 Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	23
4.7 Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	26
4.8 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	34
4.9 Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	40
4.10 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	40
4.11 Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	41
4.12 Дуу шуугиан, доргио чичиргээнээс үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	41
4.13 Цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал уснаас гарах үнэрээс нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	44
4.14 Нийгэм эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	46
5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	48
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	48
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	49

8.	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	57
9.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	65
9.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	65
9.2	Дуу шуугианы хяналт шинжилгээ	68
9.3	Усны чанарын хяналт шинжилгээ	69
9.4	Хөрсний хяналт шинжилгээ.....	70
10.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	72
11.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	74
12.	ДҮГНЭЛТ	75
	ХАВСРАЛТ 1. ГБОНМТ БОЛОН ТҮҮНИЙ ДЭД МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНҮҮДИЙН НҮҮР ХУУДАС	77
	ХАВСРАЛТ 2. ТООСЖИЛТ ДАРАХ УСАЛГААНЫ БҮРТГЭЛ.....	78
	ХАВСРАЛТ 3. БОХИР УС ЦУГЛУУЛАХ ТАНКНЫ ШИНГЭН НЭВТРҮҮЛЭХ СОРИЛЫН ТАЙЛАН.....	79
	ХАВСРАЛТ 4. УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАРТАЙ БАЙГУУЛСАН АЖ АХУЙН ГЭРЭЭ	80
	ХАВСРАЛТ 5. УНДНЫ УСНЫ ТАНКАНД ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ АКТ.....	81
	ХАВСРАЛТ 6. ДУУ ЧИМЭЭНИЙ ХЭМЖИЛТИЙН БҮРТГЭЛ.....	82
	ХАВСРАЛТ 7. ХОР АЮУЛЫН ЛАВЛАХ МЭДЭЭЛЛИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ЖИШЭЭ	83
	ХАВСРАЛТ 8. ХОГ ХАЯГДЛЫН БҮРТГЭЛ	84
	ХАВСРАЛТ 9. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРИУ (АГААРЫН ЧАНАР)	85
	ХАВСРАЛТ 10. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРИУ (ХӨРСНИЙ ЧАНАР)	86
	ХАВСРАЛТ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ БАТАЛГААНЫ ТӨЛБӨРИЙН ШИЛЖҮҮЛГИЙН БАРИМТ	87

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1 УДБҮ-ийн төслийн талаарх товч мэдээлэл.....	7
Хүснэгт 1-2 УДБҮ-ийн талбайн эргэлтийн цэгүүд	8
Хүснэгт 2-1: 2022 онд гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт	9
Хүснэгт 3-1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн зардлын задаргаа, 2022.10.25-ны байдлаар	11
Хүснэгт 3-2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа, 2022.10.25-ны байдлаар	12
Хүснэгт 3-3 Хяналт шинжилгээний үйл ажиллагааны төсвийн задаргаа, 2022.10.25-ны байдлаар.....	12
Хүснэгт 4-1: Газрын гадарга, хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
Хүснэгт 4-2: Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
Хүснэгт 4-3: Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20
Хүснэгт 4-4: Гадаргын усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	23
Хүснэгт 4-5 УДБҮ-ийн нийт усны зарцуулалт, 2022 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар .	26
Хүснэгт 4-6: Газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	27
Хүснэгт 4-7: Хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	34
Хүснэгт 4-8: Дуу шуугианаас нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	42
Хүснэгт 4-9: ТЦБ-ын лаг хатаах талбайгаас гарах хүхэрт устөрөгчөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт	44
Хүснэгт 4-10: Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	46
Хүснэгт 7-1: УДБҮ-ийн төслийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	49
Хүснэгт 8-1 Нийт хог хаягдлын хэмжээ, 2022 оны 10-р сарын 25-ны байдлаар.....	58
Хүснэгт 8-2: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	61
Хүснэгт 9-1: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй агаарын чанарын хяналт шинжилгээ	65
Хүснэгт 9-2 2022.09.30-ны өдрийн агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн тайлан.....	66
Хүснэгт 9-3 2022.10.20-ны өдрийн агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн тайлан.....	66
Хүснэгт 9-4: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй дуу шуугианы хяналт шинжилгээ	68
Хүснэгт 9-5: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй усны чанарын хяналт шинжилгээ	69
Хүснэгт 9-6: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй хөрсний хяналт шинжилгээ.....	70
Хүснэгт 9-7 Хөрсний чанарын хэмжилтийн хүнд металлын агууламжийн тайлан	71
Хүснэгт 9-8 Хөрсний чанарын хэмжилтийн агрохимийн үр дүнгийн тайлан.....	71
Хүснэгт 10-1 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт.....	72
Хүснэгт 11-1: Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах тайлагналын биелэлт.....	74

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1 УДБҮ төслийн барилгын ажил хэрэгжих талбайн байршил.....	8
Зураг 4-1 Төслийн урьдчилсан зааварчилгааны жишээ	12
Зураг 4-2 Төслийн урьдчилсан зааварчилгаанд хамрагдаж буй байдал (а), урьдчилсан зааварчилгааны бүртгэлийн хуудас (б), өндөр эрсдэлтэй ажлын зааварчилгааны бүртгэлийн хуудас (в)	13
Зураг 4-3 Төслийн талбайд байршуулсан асгаралт шингээгч иж бүрдэл	16
Зураг 4-4 Төслийн талбайд нэвтрэх тоног төхөөрөмжийн хяналт хийж буй байдал	19
Зураг 4-5 Лед гэрэл суурилуулсан байдал	19
Зураг 4-6 Талбайн усалгаа хийж буй байдал	22
Зураг 4-7 Төслийн талбайд замын тэмдэг байршуулсан	22
Зураг 4-8 Төслийн талбайн түр замыг тэгшилж, дайрга дэвссэн байдал.....	22
Зураг 4-9 Ачааны машины тэвшийг хучиж тээвэрлэлт хийж буй байдал	22
Зураг 4-10 Төслийн талбайд өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээ хийгдэж буй байдал	25
Зураг 4-11 Гүйцэтгэгчийн түр оффисын бохир цуглуулах танк болон танк суурилуулж буй байдал, 2022.08.16	32
Зураг 4-12 Инженерийн түр оффисын бохир цуглуулах танканд шингэн нэвчүүлэх сорил хийж буй болон танк суурилуулж буй байдал, 2022.10.13	32
Зураг 4-13 УСУГ-ын зориулалтын тээврийн хэрэгслээр бохир ус соруулж буй байдал	33
Зураг 4-14 Түр оффист автомат цорго болон 2 сонголттой суултуур суурилуулсан байдал.....	33
Зураг 4-15 Ундны усны танк цэвэрлэж буй байдал.....	33
Зураг 4-16 Хөл газрын ургамлыг цэвэрлэхээс өмнө болон цэвэрлэсний дараах зураг	40
Зураг 4-17 Шувуу үргээгч суурилуулж буй байдал	41
Зураг 4-18 Шаардлагатай тохиолдолд чихний бөглөөгөөр ханган ажиллаж байна	44
Зураг 4-19 Төслийн талбайд хэмжилт хийж буй зөөврийн дуу чимээ хэмжигч багаж	44
Зураг 7-1 Төслийн талбайд хэрэгждэг хувийн хамгаалах хэрэгслийн шаардлага.....	54
Зураг 7-2 Төслийн талбайд осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлж буй байдал	55
Зураг 7-3 Төслийн талбайд хэрэгждэг хөдөлмөрийн аюулгүй байдлын “Алтан дүрэм”	57
Зураг 8-1 Хог хаягдал ангилан ялгах заавар.....	58
Зураг 8-2 Төслийн талбайн бэлтгэл ажлын хугацаанд талбайд байршуулсан хогийн цэг	60
Зураг 8-3 Хуванцар хаягдал цуглуулдаг хогийн сав	60
Зураг 8-4 Түр оффисын хог хаягдал ангилан ялгалтын сав	60
Зураг 8-5 2023 онд төслийн талбайд бий болгохоор төлөвлөж буй барилгын хаягдлын нэгдсэн хогийн цэг (Зүүн талаас: Бусад хог, Мод, Төмөр, Аюултай хаягдал).....	60
Зураг 8-6 2023 онд төслийн талбайд бий болгохоор төлөвлөж буй ахуйн хаягдлын нэгдсэн хогийн цэг (Зүүн талаас: Хүнсний хаягдал, Дахин боловсруулах хаягдал, Бусад хаягдал).....	60
Зураг 8-7 Төслийн талбайн бэлтгэл ажлын үед ашиглаж буй нийт ажилчдад зориулсан ариун цэврийн байгууламж	64
Зураг 9-1 Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал 2022.09.30	67
Зураг 9-2 Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал 2022.10.20	67
Зураг 9-3 Дуу чимээний хэмжилт хийж буй байдал.....	69
Зураг 9-4 Хөрсний чанарын хяналт шинжилгээний дээж авч буй байдал 2022.09.30	72

ХУРААНГУЙ ҮГИЙН ЖАГСААЛТ

БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БУ	Барилга угсралт
ГБОНМТ	Гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
ДЦС	Дулааны цахилгаан станц
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ММСС	Монголын Мянганы сорилтын сан
МСК	АНУ-ын Мянганы сорилтын корпорац
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОУСК	Олон улсын санхүүгийн корпорац
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЦБ	Төв цэвэрлэх байгууламж
УДБҮ	Ус дахин боловсруулах үйлдвэр
УСУГ	Ус Сувгийн Удирдах Газар
ХАБЭАБО	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин
ХАЛМ	Хор аюулын лавлах мэдээлэл
ХУДБ	Хаягдал ус дахин боловсруулах
ШТМ	Шатах тослох материал
ШТЦБ	Шинэ төв цэвэрлэх байгууламж
GRM	Grievance Redress Mechanism – Гомдол барагдуулах механизм
MNS	Mongolian national standard

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн тодорхойлолт

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах замаар ядуурлыг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газар Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын байгууллага болох Мянганы сорилтын корпорац (“МСК” гэх)-ын хооронд байгуулсан “Мянганы сорилтын компакт гэрээ”-ний хүрээнд Улаанбаатар хотын унд ахуйн ус хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын тооцоолж буй усны эрэлтийг хангах зорилттой гурван төслийг хэрэгжүүлж байгаагийн нэг нь Хаягдал ус дахин боловсруулах (ХУДБ) үйл ажиллагаа юм .

Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын Шинэ төв цэвэрлэх байгууламж (ТЦБ)-аас цэвэрлэгдээд Туул гол руу нийлүүлэх хаягдал усны тодорхой хэсгийг дахин боловсруулж, гурав болон дөрөвдүгээр Дулааны цахилгаан станцуудын (ДЦС) техникийн усны зориулалтаар эргүүлэн ашиглана.

Эдгээр ДЦС-ууд нь жилд 21.0 сая шоо метр ($50^{\circ}000$ м³/хон) усыг газрын доорх эх үүсвэрээс авч ашигладаг бөгөөд үүнээс 15.0 сая шоо метр усыг (нийт хэрэглээний ойролцоогоор 70%) хөргөлт, угаалга цэвэрлэгээ, үнс зайлуулах, гал эсэргүүцэх систем зэрэг техникийн үйл ажиллагаанд ашигладаг. “ДЦС-3,” “ДЦС-4” ТӨХК-уудын хүчин чадлыг үе шаттай нэмэгдүүлсний дараа 2034 он гэхэд дээрх зориулалтаар ашиглаж буй усны хэрэглээ жилд 18.0 сая шоо метр хүртэл нэмэгдэхээр тооцсон бөгөөд төсөл хэрэгжсэнээр станцууд уг усыг дахин боловсруулсан усаар орлуулан хэрэглэнэ.

ДЦС-уудын техникийн зориулалтаар ашиглаж буй усыг дахин боловсруулсан усаар орлуулснаар гүний усны эрэлтийг бууруулж, улмаар чөлөөлөгдсөн эх үүсвэрийг Улаанбаатар хотын унд, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэхэд ашиглах боломжийг бий болгох юм.

Хаягдал ус дахин боловсруулах төслийг дараах 3 багцад хувааж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Ус дамжуулах систем, ДЦС-уудын техникийн усны схемийн өөрчлөлтийн зураг төсөл, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, шугамын трассын дагуу газар чөлөөлөх төлөвлөгөө боловсруулах зөвлөхийн үйлчилгээ
- Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
- Ус дамжуулах систем, ДЦС-уудын техникийн усны схемийн өөрчлөлтийн барилга угсралтын ажил

“М-Си-Эс Проперти” ХХК нь ХУДБ төслийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох “Ус дахин боловсруулах үйлдвэр” (УДБҮ)-ийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байгаа ба энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь УДБҮ-ийн төслийн хүрээнд хэрэгжинэ.

Хүснэгт 1-1 УДБҮ-ийн төслийн талаарх товч мэдээлэл

Төслийн нэр:	Ус Дахин Боловсруулах Үйлдвэр
Ерөнхий үнэлгээний дугаар:	13/4193
Төслийн санхүүжүүлэгч:	Мянганы сорилтын корпорац, Монгол Улсын Засгийн газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Монголын Мянганы сорилтын сан” УТҮГ
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Юнескогийн гудамж, МПМ цогцолбор, 5 давхар. Харилцах утас: 77111710, 85002169

	Төслийн захирал: Т.Хишигт
Төслийн гүйцэтгэгч:	“М-Си-Эс Проперти” ХХК
Төслийн зорилго:	Хаягдал усыг дахин боловсруулж ДЦС#3 болон ДЦС#4 ТӨХК-уудад ашигласнаар газрын доорх цэнгэг усны нөөц хэмнэгдэж, ирээдүйн Улаанбаатар хотын усны нөөцийн найдвартай байдлыг хангах.
Хүчин чадал:	Хоногт 50,000 м ³ хаягдал усыг дахин боловсруулах
Төслийн байршил:	Улаанбаатар хот, СХД 20-р хорооны нутагт Шинэ төв цэвэрлэх байгууламж (ШТЦБ)-ийн баруун талд 4.5 га талбайд барихаар төлөвлөсөн.
Төсөл хэрэгжих хугацаа:	2022.06.06 - 2025.05.04
Төслийн цар хүрээ:	4.5 га талбайн 1/3 хэсэгт буюу 1.5 га талбайд УДБҮ-ийн барилга байгууламжууд баригдана.

1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил

УДБҮ-ийг Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт Шинэ төв цэвэрлэх байгууламж (ШТЦБ)-ийн баруун талд 4.5 га талбайд барихаар төлөвлөсөн.

Зураг 1-1 УДБҮ төслийн барилгын ажил хэрэгжих талбайн байршил



Хүснэгт 1-2 УДБҮ-ийн талбайн эргэлтийн цэгүүд

№	Уртраг	Өргөрөг	Талбай, га
1	106° 44' 55.13"	47° 54' 8.512"	4.5
2	106° 45' 3.180"	47° 54' 9.300"	
3	106° 45' 4.684"	47° 54' 0.709"	
4	106° 44' 56.70"	47° 54' 0.013"	

1.3 Төслийн үндсэн зорилго

Энэхүү төслийн үндсэн зорилго нь ДЦС#3, ДЦС#4 ТӨХК-уудад ашигладаг газрын доорх усны нөөцийг хэмнэх замаар Улаанбаатар хотын ундны усны нөөцийг нэмэгдүүлэх юм. ДЦС#3, ДЦС#4 ТӨХК-ууд нь Туул голын сав газарт байрлах өөрсдийн эзэмшлийн ус хангамжийн худгуудаас олборлосон усаар техникийн усны хэрэгцээгээ хангадаг ба хөргөлт, угаалга

цэвэрлэгээ, үнс зайлуулах, гал эсэргүүцэх систем зэрэг техникийн үйл ажиллагаанд жилд 15 сая м³ газрын доорх усыг татаж ашигладаг. Монгол Улсын Засгийн газар (МУЗГ) хоногт 250,000 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай ШТЦБ төслийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаа билээ. Төлөвлөж буй ШТЦБ нь бохир усыг MNS 4943:2015 стандартад нийцүүлэн цэвэрлэж Туул гол уруу нийлүүлнэ. Мянганы сорилтын сан (МСС) нь ХУДБ төслийн хүрээнд дээрх байгууламжаас гарах MNS 4943:2015 стандартад нийцүүлэн цэвэрлэсэн усыг дахин боловсруулах үйлдвэр (УДБҮ)-ийг тус ШТЦБ-ийн дэргэд барихаар төлөвлөж байгаа ба тус үйлдвэр нь хоногт 50,000 м³ хаягдал ус цэвэрлэх хүчин чадалтай байна. УДБҮ нь дахин боловсруулсан усаа ДЦС#3, ДЦС#4-д техникийн усны зориулалтаар нийлүүлэх ба ингэснээр эдгээр станцуудад ашиглагддаг газрын доорх усыг дахин ашиглах цэвэрлэсэн усаар орлуулах боломж бүрдэнэ.

2. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


2022 онд Ус дахин боловсруулах үйлдвэр (УДБҮ)-ийн төслийн үндсэн барилгажилттай холбоотой ухлага, суурийн бэлтгэл ажил, хөрсний ус шавхах гэх мэт барилгын үйл ажиллагаа явагдаагүй бөгөөд зөвхөн төслийн талбайн бэлтгэл ажил болох дараах ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Үүнд:

- Талбайн тэгшилгээ, цэвэрлэгээ болон шарилж цэвэрлэх талбайн бэлтгэл ажил;
- Түр оффис (Инженер болон гүйцэтгэгчийн түр оффис) байршуулах болон түүний дагалдах ажлууд;
- Түр хашаа суурилуулах;
- Түр зам болон явган хүний зам засах;
- Тэмдэг болон хаалт хашилт байрлуулах;
- Барилгын ажилчдын түр ариун цэврийн контейнерт хэрэглэх ахуйн усны хэрэглээнд болон цаашид барилгын үйл ажиллагаанд ашиглах зориулалттай гүний худаг өрөмдөх.


зэрэг бэлтгэл ажлууд хамаарна. Дээрх төлөвлөгдсөн бэлтгэл ажлуудаас Хүснэгт 2-1-т тусгагдсан ажлууд бүрэн хийгдэж дууссан. Харин барилгын ажилчдын түр ариун цэврийн контейнерт хэрэглэх ахуйн усны хэрэглээнд болон цаашид барилгын үйл ажиллагаанд ашиглах зориулалттай нэг гүний худаг өрөмдөх ажил 2022 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар хийгдэж эхлээгүй байгаа ба тус оны 11-р сард багтаан хийж эхлэхээр төлөвлөгдөж байна.

УДБҮ-ийн төслийн талбайн бэлтгэл ажил 2022 оны 8-р сарын 2-ны өдрөөс эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд гүйцэтгэсэн талбайн бэлтгэл ажлын мэдээллийг Хүснэгт 2-1-ээс дэлгэрэнгүй харна уу.

Хүснэгт 2-1: 2022 онд гүйцэтгэсэн ажлуудын жагсаалт

Гүйцэтгэсэн ажил	Гүйцэтгэсэн огноо	Зураг
Түр хашаа суурилуулах	Эхэлсэн хугацаа- 2022.08.02 Дууссан хугацаа- 2022.08.15	

<p>Түр зам болон явган хүний зам засах</p>	<p>Эхэлсэн хугацаа- 2022.08.10 Дууссан хугацаа- 2022.08.11</p>	
<p>Талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ</p>	<p>Эхэлсэн хугацаа- 2022.08.12 Дууссан хугацаа- 2022.08.12</p>	
<p>Талбайн шарилж цэвэрлэх</p>	<p>Эхэлсэн хугацаа- 2022.08.15 Дууссан хугацаа- 2022.08.31</p>	
<p>Тэмдэг болон хаалт, хашилт байрлуулах</p>	<p>Эхэлсэн хугацаа- 2022.08.26 Дууссан хугацаа- 2022.09.15</p>	
<p>Инженерийн түр оффис байршуулах болон түүний дагалдах ажлууд</p>	<p>Эхэлсэн хугацаа- 2022.09.01 Дууссан хугацаа- 2022.10.28</p>	

<p>Гүйцэтгэгчийн түр оффис байршуулах болон түүний дагалдах ажлууд</p>	<p>Эхэлсэн хугацаа- 2022.08.02 Дуусах хугацаа- 2022.11.04</p>	
--	---	--

3. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

УДБҮ-ийн төслийн 2022 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах ажлын зардалд нийт 32,844,000₮ төсөвлөсөн бөгөөд 2022 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар нийт 31,975,560₮ буюу нийт төсвийн 97.36%-ийг зарцуулаад байна. Үлдэгдэл төсвийн зарцуулалтыг 2022 оны 11-р сараас 12-р сарыг дуусах хүртэлх 2 сарын хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж байгаа бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нийт 2,109,000₮ (Агаарын чанарын шинжилгээнд 1,309,000₮, усны чанарын шинжилгээнд 800,000₮) болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах ажилд нийт 400,000₮ зарцуулагдахаар байна.

Гүйцэтгэгч нь “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.9-р заалтын дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50%-тай тэнцэх барьцаа мөнгийг 2022 оны 10-р сарын 18-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн байгаль орчин нөхөн сэргээх баталгааны төрийн сангийн тусгай дансанд байршуулсан (Хавсралт 11).

Хүснэгт 3-1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн зардлын задаргаа, 2022.10.25-ны байдлаар

№	Зардлын төрөл	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсөв	19,959,000	25,295,500
2	Орчны тохижуулалт, цэцэрлэгжүүлэлтийн төсөв	-	-
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв	-	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	1,540,000	3,103,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний төсөв	5,500,000	2,352,560
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв	5,445,000	1,224,500
7	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	-	-

8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төсөв	400,000	-
	Нийт	32,844,000	31,975,560

Хүснэгт 3-2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа, 2022.10.25-ны байдлаар

№	Үйл ажиллагааны төрөл	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Газар	1,500,000	990,000
2	Уур амьсгал	-	759,000
3	Агаарын чанар	1,814,000	1,143,500
4	Гадаргын ус	-	-
5	Газрын доорх ус	11,800,000	15,740,000
6	Хөрсөн бүрхэвч	1,000,000	1,496,000
7	Дуу шуугиан	1,370,000	1,672,000
8	Үнэр	2,475,000	3,495,000
	Нийт	19,959,000	25,295,500

Хүснэгт 3-3 Хяналт шинжилгээний үйл ажиллагааны төсвийн задаргаа, 2022.10.25-ны байдлаар


№	Үйл ажиллагааны төрөл	Төлөвлөгөөнд төсөвлөгдсөн хэмжээ, төг	Зарцуулагдсан төсвийн хэмжээ, төг
1	Агаарын чанар	3,500,000	1,116,500
2	Дуу шуугиан	-	-
3	Усны чанар	1,600,000	-
4	Хөрсний чанар	345,000	108,000
	Нийт	5,445,000	1,224,500

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1 Байгаль орчны мэдлэг олгох сургалт зохион байгуулах

М-Си-Эс Проперти ХХК нь байгаль орчны бодлогын хүрээнд нийт ажилчдын байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг хангах үүднээс мэдлэг олгох сургалтыг төслийн урьдчилсан зааварчилгааны сургалтаар дамжуулан нийт ажилчдад тогтмол зохион байгуулж байна. Энэ сургалтад төслийн талбайд нийт ажилчдын дагаж мөрдөж, хэвшүүлэх шаардлагатай “Ногоон дүрэм”, хог хаягдлаа ангилан хаях заавар, асгаралтаас сэргийлэх арга хэмжээ болон соёлын өвийн олдвор илрүүлсэн тохиолдолд авах арга хэмжээ зэргийн талаар тусгасан байдаг (Зураг 4-1). 2022 оны 10-р сарын байдлаар нийтдээ 130 ажилтан 41 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан байгаль орчны мэдлэг олгох сургалтад хамрагджээ (Зураг 4-2).

Зураг 4-1 Төслийн урьдчилсан зааварчилгааны жишээ



WRP төсөл

Цахилгааны хэвнэлт

- Ашиглаагүй үедээ унтраах (Урьдны өрөөний гэрлийг ашигласны дараа унтраах, ашиглаагүй цахилгаан хэрэгсэл залуураар нь салгаж хэвнэл)
- Байгалийн агааржуулалт ашиглах
- Өрөөний температурыг зөв тохируулах

Цаасны хэвнэлт

- Аль болох цаасан дээр хэвнэлгүйгээр компьютер дээрээ унших, и-мэйлээр хэвнэл
- Цаасны 2 тал дээр хэвнэл
- Ур ашиггүй хэвнэлт хийхгүй байх
- Цаасны ар талыг ашиглах
- Салфетаны хэрэглээгээс татгалзах (гар хялганч, алчуур гэх мэтээр ашиглах)
- Хаагдал бичгийн цаасыг дахин боловсруулах

Усны хэвнэлт

- Зөв сонгох (Сууцлуурын усг татагдах бага даралтыг сонгох, угалтуурын усыг гоошуулагдах бага даралтыг сонгох)
- Усаа ганах (Ус дусалж байгаа шуган хоолойг асаах, хаах)

Хөгжиг хэвнэлт

- Хөгжиг эх үүсвэр дээр нэвчилсэн хэвнэл
- 1 удаагийн хэрэглээгээс татгалзах
- Цаасны ар талыг ашиглах
- Дахин ашиглах боломжтой материалыг дахин ашиглах

Аль ажиллагчдын хэрэгжүүлэх арга хэмжээ

WRP төсөл

Тур оффис

Оффист нэгдсэн хөлийн сав байрлуулах

Ар цаас цуглуулах хэсгийг принтерийн хажууд гаргана

Барилгын талбай

Цаас Хаягдал зай Хувицар Бусад

Хийний бодисын сав баглаа Төмөр Мод Барилгын бусад хог

WRP төсөл

Бид оффисын орчинд хог хаягдлыг 3 төрөлд ангилан хаядаг.

YOUR ACTION MATTERS!

LANDFILL (Red bin): No food, plastic, liquids, or garbage

RECYCLE (Yellow bin): No food, plastic, liquids, or garbage

RECYCLE (Blue bin): No food, plastic, liquids, or garbage

Мэдээлэх урсгал

Түүх дурсгалын одвор санамсаргүй илрүүлэх

- Нэн даруй ажлаа зогсоох
- Шууд удирдлагаа мэдэх
- Гүйцэтгэлийн ХАБЭА-ны баг/байгаль орчны ажигтанд мэдээлэх
- Түүх дурсгалын одвор олсон тохиолдолд бөгөөд мөнгөтэй бөгөөд, одворын зургийг авах
- Захиалч болон эрх бүий нэрэгжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэх
- Эрх бүий нэрэгжлийн байгууллага одворыг малталт хийж буран гуйцдаг гарган авах
- Барилга урсгалын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох
- Тур зогссон барилгын ажлыг ахлуулж

Илэрсэн одворыг хангаалалтад авах арга хэмжээг зохион байгуулах

Зураг 4-2 Төслийн урьдчилсан зааварчилгаанд хамрагдаж буй байдал (а), урьдчилсан зааварчилгааны бүртгэлийн хуудас (б), өндөр эрсдэлтэй ажлын зааварчилгааны бүртгэлийн хуудас (в)



СУРГАЛТЫН БҮРТЭЭЛ
COURSE TRAINING RECORD

Урьдчилсан зааварчилгаа

Аймаг/Төсөл (Department/Project): WRP төсөл
Хугацаа (Period time): I сар
Сургагч (Trainer): В.Батбаяр

Огноо / Date: 2022.09.29
Дугаар / Training no:
Хавсралт (Appendix):

Сургалтын агуулга (Training content): Төслийн тухайн ХАБЭА-н шаардлага, үйл ажиллагааны мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, байгаль орны үйл ажиллагааны мэдэг олох, илгэм жондрын шаардлага / Project site HSE requirements, operational information, safety instructions, environmental requirements training, social gender requirements

Оролцсон (Attendance):

№	Овог Нэр (Name)	Компаний нэр (Company name)	Аймаг туслаа (Region)	Утасны дугаар / Phone number	Гарын үсэг / Signature
1	Н.Зуураг	Тангас	МБР	88077447	[Signature]
2	В.Аюулбаяр	Тангас	МБР	98252182	[Signature]
3	В.Аюулбаяр	Тангас	МБР	8850162	[Signature]
4	З.Тангас	Тангас	МБР	8855687	[Signature]
5	Н.Минжир	Тангас	МБР	8851887	[Signature]
6	Н.Минжир	Тангас	МБР	8810766	[Signature]
7					
8					
9					
10					
11					
12					

Сургагчийн гарын үсэг / Trainer's signature: [Signature]

СУРГАЛТЫН БҮРТЭЭЛ
COURSE TRAINING RECORD

Өндөр эрсдэлтэй ажлын зааварчилгаа

Аймаг/Төсөл (Department/Project): WRP төсөл
Хугацаа (Period time): I сар
Сургагч (Trainer): В.Батбаяр

Огноо / Date: 2022.09.08
Дугаар / Training no: 3
Хавсралт (Appendix):

Сургалтын агуулга (Training content): Өндөр эрсдэлтэй ажлын үеийн ХАБЭА-н шаардлага, үйл ажиллагааны мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа / HSE requirements, operational information and safety instructions for work at height

Оролцсон (Attendance):

№	Овог Нэр (Name)	Компаний нэр (Company name)	Аймаг туслаа (Region)	Утасны дугаар / Phone number	Гарын үсэг / Signature
1	Э.Батбаяр	Чулуун хаяг	Төв	96267733	[Signature]
2	В.Аюулбаяр	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
3	А.Батбаяр	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
4	З.Тангас	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
5	Д.Батбаяр	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
6	Батбаяр	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
7	Б.Батбаяр	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
8	Д.Батбаяр	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
9	Ц.Минжир	Чулуун хаяг	Төв	88000000	[Signature]
10					
11					
12					

Сургагчийн гарын үсэг / Trainer's signature: [Signature]

4.2 УДБҮ-ийн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагалдах төлөвлөгөөнүүд

Гүйцэтгэгч нь УДБҮ-ийн төслийн барилгын үйл ажиллагааны бүхий л үе шатанд хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага түвшинд байлгахыг зорих бөгөөд холбогдох хууль, зохицуулалтын шаардлагууд болон олон улсын стандартын шаардлагуудыг биелүүлж ажиллана. Үүний тулд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Гүйцэтгэгчийн байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (ГБОНМТ)”-г Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), Дэлхийн банк, Мянганы сорилтын корпорац (МСК) болон Монголын Мянганы сорилтын сан (МСС)-гийн шаардлагын дагуу боловсруулж байгаа ба төслийн захиалагчаар хянуулж, батлуулна. Энэхүү ГБОНМТ-нд байгаль орчны чиглэлээр дараах 7 төрлийн дэд менежментийн төлөвлөгөө багтана. Үүнд:

- Агаарын чанар болон дуу чимээний менежментийн төлөвлөгөө;
- Түүх, соёлын өвийн олдвор илэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө;
- Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө;
- Хөрс хамгаалах төлөвлөгөө;
- Талбай чөлөөлөх болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө;
- Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө.

Гүйцэтгэгч нь дээрх 7 төлөвлөгөөг боловсруулж (Хавсралт 1а – 1ж), төслийн захиалагчаар хянуулж, батлуулахаар хүргүүлсэн байгаа бөгөөд төслийн захиалагчийн хяналтын явц үргэлжилж байна.

Тус ГБОНМТ нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнөөс тусдаа боловсруулагдаж байгаа ч төслийн хугацаанд байгаль орчныг хамгаалах чиглэлээр гүйцэтгэх арга хэмжээнүүд нь ижил юм. Иймд, гүйцэтгэгч нь төслийн нийт хугацаанд ГБОНМТ болон түүний дэд менежментийн төлөвлөгөөнүүд, мөн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллана.

4.3 Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

2022 онд УДБҮ-ийн төслийн хүрээнд үндсэн барилгын суурь бэлтгэх ухлагын ажил явагдаагүй тул тус онд төслийн талбайн газрын гадарга, хэвлий дахин эвдэгдэх нөхцөл үүсээгүй болно. Харин төслийн талбайн бэлтгэл ажлын үед буюу барилгын ажилчдын байрлах түр байгууламжийг барихад ашиглах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шатах тослох материалын асгаралт үүсэхээс сэргийлж дараах 3 бүлэг ажлыг төслийн талбайд хэрэгжүүлэн ажилласан.

Тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ бүрэн биелсэн байна.

Хүснэгт 4-1: Газрын гадарга, хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Барилгын ажилд ашиглах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс шатах тослох материал, хөргүүрийн шингэн асгарч газрын гадарга, хэвлийг бохирдуулах	Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-нд асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө тусгагдан боловсруулагдсан. Тус төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1е-ээс дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.
2		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай агуулгыг тусгасан ба 2022 оны 10-р сарын байдлаар нийт 130 ажилтанд	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.

		ажиллагсад сургалтаар дамжуулан олгосон байх			41 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгааны сургалт олгосон байна (Дэлгэрэнгүй мэдээллийг 4.1 хэсгээс харна уу).	
3		Асгаралт шингээгч иж бүрдлийг талбайд байршуулсан байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайд асгаралт шингээгч иж бүрдлийг 2022.08.12- ны өдөр түр оффисын барилгын зүүн талд байршуулсан (Зураг 4-3).	990,000
					Нийт	990,000

Зураг 4-3 Төслийн талбайд байршуулсан асгаралт шингээгч иж бүрдэл



*Байршил: Түр оффисын барилгын зүүн талд



- 240 литрийн багтаамжтай
- 48 см х 43 см хэмжээтэй, хонхорхойтой, шивсэн алчуур – 40 ш
- Шал цэвэрлэх модны үртэс, шуудайтай – 10 кг х 3 ш
- 1.2 м х 75 мм хэмжээтэй хөвөө – 4 ш
- 45 см х 45 см шингээгч дэр – 2 ш
- Резинэн, зузаан бээлий – 2 ш
- 450 мм х 720 мм хогийн гялгар уут – 10 ш
- Хогийн шүүр, тосгуур – 1 ш
- Асгаралтын иж бүрдлийн ашиглах зааварчилгаа – 1 ш

4.4 Уур амьсгалд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

2022 онд УДБҮ-ийн төслийн түр байгууламжийн бэлтгэл ажлын хүрээнд ашиглах машин, механизмуудын түлшний шаталтаас болон түр барилга байгууламжийн цахилгааны хэрэглээнээс нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) ялгарч агаар мандал дах хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлж болзошгүй тул дараах 6 бүлэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-2: Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	УДБҮ-ийн түр байгууламжийг барихад ашиглах тээврийн хэрэгслүүдийн түлшний шаталтаас болон	Техникийн үзлэгт бүрэн хамрагдсан (хөдөлгүүрийн утаа, түүний найрлага дах хорт бодис, тортогжилтын хэмжээ нь MNS 5013, MNS 5014 стандартад тогтоосон хэмжээнээс хэтрээгүй) тээврийн хэрэгслүүдийг төслийн талбайд ашиглах	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна.	Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдийг түрээслэх буюу туслан гүйцэтгэгчээс нийлүүлж буй тул зардал гараагүй.
2	түр байгууламжийн цахилгааны хэрэглээнээс CO ₂ ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх	Төслийн талбайд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал (тос масло, ШТМ-ын асгаралт үүсгэдэггүй байх, яндангаас гарах утааны түвшин хэвийн байх г.м)-д сар бүр үзлэг шалгалт хийх ба үл тохирол илэрсэн тохиолдолд залруулах арга хэмжээ авах зааварчилгааг холбогдох талд өгч, хэрэгжилтийг хангуулах	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна (Зураг 4-4). Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил үүсээгүй тул зардал гараагүй.
3		Тээврийн хэрэгслийг зогсоолд байрлуулахдаа	УДБҮ-ийн төслийн талбайн	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-

		хөдөлгүүрийг заавал унтраасан байх	нийт тээврийн хэрэгсэл			
4		Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг ашиглахгүй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
5		Төслийн талбайд ашиглах нийт тээврийн хэрэгсэлд Евро 5 стандартын шатахуун ашиглахыг шаардах ба тус стандартын шатахуун худалдан авсан тухай баримт мэдээллийг гүйцэтгэгчид хүргүүлж байх зохицуулалтыг хийх (Энэхүү шаардлага нь дизель түлш ашигладаг тээврийн хэрэгсэлд хамаарахгүй болно)	УДБҮ-ийн төслийн талбайн холбогдох тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ашиглаж буй гүйцэтгэгчийн өмчийн тээврийн хэрэгсэлд Евро 5 стандартын шатахуун ашиглаж байна. Төслийн үндсэн барилгын явцад ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч компаниудын ажил үйлчилгээний гэрээнд холбогдох шаардлагыг 2022 оны 12-р сард багтаан тусгахаар төлөвлөж байна.	-
6		Түр оффисын гэрэлтүүлэгт лед гэрэл ашиглах	УДБҮ-ийн төслийн талбай, түр оффисын барилга	Бүрэн хэрэгжсэн	Захиалагчийн болон гүйцэтгэгчийн түр оффисын гэрэлтүүлэгт нийт 123 ш лед гэрэл төлөвлөгдсөн байгаа ба 2022 оны 10-р сарын байдлаар 100 ш лед гэрэл суурилуулсан. Үлдэгдэл 23 ш лед гэрлийг 2022 оны 11-р сард багтаан суурилуулахаар төлөвлөж байна (Зураг 4-5 а).	Лед гэрлийн зардал нь туслан гүйцэтгэгчийн гэрээний үнийн дүнд багтсан.
			УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн түр гэрэлтүүлэгт нийт 44 ш лед прожектор суурилуулахаар төлөвлөж байгаа ба 2022 оны 10-р сарын байдлаар 3 ш лед прожектор суурилуулсан байна (Зураг 4-5 б).	759,000 (3 ш * 253,000₮)
					Нийт	759,000

4.5 Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгаснаар агаарын чанарт нөлөөлөх үндсэн эх үүсвэр нь төслийн талбайд ашиглагдах машин, техникүүд байх ба машин, техникүүдийн хөдөлгөөнөөс тоосонцор (PM_{2.5} болон PM₁₀), хөдөлгүүрээс бохирдуулагч хийнүүд (SO₂, NO₂) агаар мандалд тархаж, агаарын чанарт нөлөөлж болзошгүй тул дараах арга хэмжээнүүдийг 2022 онд төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4-3: Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Барилгын материал тээвэрлэлт, түр байгууламжийн угсралтын үед ашиглах техник хэрэгслээс ялгарах тоос, бохирдуулагчий	Дулааны улиралд замын тоосжилт дарах усалгааг тогтмол хийх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед тоосжилт ихээр үүссэн өдрүүдэд нийт 7 тн усыг тоосжилт дарах усалгаанд зарцуулсан (Зураг 4-6). Тоосжилт дарах усалгааны бүртгэлийг Хавсралт 2-оос харна уу.	46,500
2		Төслийн талбайд автомашины хурдыг 10км/цаг хүртэл хязгаарлах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн түр замын тэмдэгт автомашины хурдыг 10км/цаг хүртэл хязгаарласан тэмдэг байрлуулсан ба автомашины хөдөлгөөнд талбайн менежер болон төслийн талбайн харуул хяналт тавин ажиллаж байна (Зураг 4-7).	297,000 (3 тэмдэг * 99,000) 3 тэмдэг нь 2 ш зогсоолын тэмдэг, 1 ш хурдны дээд хязгаарын тэмдэг
3		Автомашины хөдөлгөөнд ашиглах 600метр түр замын сул шороог хусах, дайрга дэвсэж тоос үүсэхийг багасгах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн автомашины хөдөлгөөнд ашиглах 790.5 м ² (85 м * 9.3 м) түр замын шороог хусаж, дайрга дэвсэж тоос үүсэхийг багасгасан (Зураг 4-8).	800,000

4		Тоосжилт, дуу шуугиан, NO ₂ , SO ₂ , H ₂ S-н хэмжилтийг тогтмол хугацаанд мэргэжлийн лабораториор хийлгүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт тусгагдсаны дагуу агаарын чанарын хэмжилтийг хэрэгжүүлж байгаа ба агаарын чанарын хэмжилтийн итгэмжлэгдсэн лабораторийн үр дүнг тус биелэлтийн тайлангийн 9.1-р хэсгээс дэлгэрэнгүй харна уу.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэгт тусгагдсан.
5		Төслийн талбайд хог хаягдал шатаах, ил гал гаргахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
6		Бараа материал, хог хаягдал, газар шорооны ажлын үед элс, шороо зэргийг тээвэрлэхдээ ачааны машины тэвшийг хучих	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын хугацаанд ачааны машины тэвшийг бараа материал, хог хаягдал зэргийг тээвэрлэх үед тогтмол хучиж ажилласан бөгөөд тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй (Зураг 4-9).	-
7		Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах ба тус төлөвлөгөөгөөр төслийн талбайд нэвтрэх нийт тоног төхөөрөмжийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, шаардлагагүй тээврийн хэрэгслийг төслийн талбайд зорчуулахгүй байх, замын усалгаа хийх аргачлал, давтамж гэх мэтийг зохицуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулж, захиалагчаар хянуулсан ба 2022.09.19-ны өдөр батлагдсан. Тухайн төлөвлөгөөний хэрэгжилтийг төслийн талбайд хангуулан ажиллаж байна. “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1ж-ээс дэлгэрэнгүй харна уу.	Тус төлөвлөгөөг гүйцэтгэгчийн төслийн баг боловсруулж, хэрэгжилтэд гүйцэтгэгчийн холбогдох талуудад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллах тул зардал гараагүй.
					Нийт	1,143,500

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр төслийн талбайд хэрэгжүүлсэн арга хэмжээний баримтжуулсан мэдээллийг дараах зургуудад үзүүлэв.

Зураг 4-6 Талбайн усалгаа хийж буй байдал



Зураг 4-7 Төслийн талбайд замын тэмдэг байршуулсан



Зураг 4-8 Төслийн талбайн түр замыг тэгшилж, дайрга дэвссэн байдал



Зураг 4-9 Ачааны машины тэвийг хучиж тээвэрлэлт хийж буй байдал



4.6 Гадаргын усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн төслийн шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд гадаргын усны эх үүсвэр багтаагүй, мөн 2022 онд барилгын талбайн хөрсний ус шавхах ажил хийгдэхгүй тул төслийн талбайн түр байгууламжийн бэлтгэл ажлын хүрээнд гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй хэдий ч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээнүүдийг тус онд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-4: Гадаргын усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Хог хаягдлыг ил задгай хаях; тээврийн хэрэгслээс ШТМ асгарах зэргээс хөрсөн бүрхэвчид бохирдол үүсэж, ширүүн бороо орох үед үерийн усаар угаагдан Туул голын усны чанарт нөлөөлж болзошгүй.	УДБҮ-ийн төслийн хүрээнд химийн бодисын асгаралтаас сэргийлэх, асгаралтын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-нд асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө тусгагдан боловсруулагдсан. Тус төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1e-ээс дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.
2	Хог хаягдлыг ил задгай хаях; тээврийн хэрэгслээс ШТМ асгарах зэргээс хөрсөн бүрхэвчид бохирдол үүсэж, ширүүн бороо орох үед үерийн усаар угаагдан Туул голын усны чанарт нөлөөлж болзошгүй.	Төслийн талбайд тээврийн хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэхийг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед машин техник, тоног төхөөрөмжийн шатахуун цэнэглэлтийг төслийн талбайд гүйцэтгээгүй бөгөөд ойролцоох шатахуун түгээх станцаас цэнэглэж, шатахууны бэлэн байдлыг хангасны дараа төслийн талбайд техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, ажил гүйцэтгэхийг сануулан шаардлага тавьж ажилласан.	-

					Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	
3		Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1д-ээс дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.
4		Төслийн талбайгаас гарах хүнд машин механизмын дугуйг угааж, цэвэрлэхээс бусад тохиолдолд төслийн талбайд машин механизм угаахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед талбайд машин механизм угаасан зөрчил гараагүй.	-
5		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан оновчтой хэрэгжүүлэх; Ил задгай хог хаяхгүй байх ба өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээг тогтмол хийх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. Өдөр бүрийн талбайн ажил дууссаны дараа ажлын байрны эмх цэгцийг хангуулах ажлыг төслийн барилга угсралтын баг болон талбайн супервайзор хариуцан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна (Зураг 4-10). “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1г-ээс дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.
6		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх, мэдлэгийг төслийн урьдчилсан	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд ангилан ялгалтын хогийн сав байршуулсан бөгөөд хог ангилан хаях тухай мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусган нийт ажиллагчдад мэдлэг олгон	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.

		зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох			ажиллаж байна (Тус биелэлтийн тайлангийн 4.1-р хэсэг болон 8-р хэсгээс дэлгэрэнгүй харна уу.)	
					Нийт	-

Зураг 4-10 Төслийн талбайд өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээ хийгдэж буй байдал



4.7 Газрын доорх усанд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан төслийн талбайд гүний худаг гаргах ажил 2022 оны 11-р сард хийгдэхээр хойшилсон ба 10-р сарын байдлаар тус ажлыг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. Туслан гүйцэтгэгч сонгогдсоны дараа цооног өрөмдөх, гүний худаг гаргах зөвшөөрлүүдийг авах ажил эхлэхээр төлөвлөгдөж байна.

2022 оны 8-р сараас эхлэн төслийн талбайн ундны болон ахуйн зориулалттай усыг зөөврөөр хангаж ажилласан бөгөөд нийт усны зарцуулалтыг доорх хүснэгтэд нэгтгэв.

Хүснэгт 4-5 УДБҮ-ийн нийт усны зарцуулалт, 2022 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар

№	Усны зарцуулалтын төрөл	Хэмжээ (2022.08-2022.10)	Тайлбар
1	Ундны ус	2.58 тн	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед ажилчдын ундны усыг “Галшинт ХХК”-ны 18.9 литрийн баллон бүхий цэвэр усаар хангаж байна.
2	Ахуйн хэрэглээний ус	34 тн	Ахуйн хэрэглээний усыг “Ус сувгийн удирдах газар”-тай байгуулсан аж ахуйн гэрээний дагуу төслийн талбайд нийлүүлж байна.
3	Зам, талбайн усалгаа	7 тн	Зам талбайн усалгааг “Охь мандал ХХК”-ийн усалгааны машинаар гүйцэтгүүлсэн.
	Нийт	43.58 тн	

2022 оны төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд газрын доорх ус буюу хөрсний ус шавхах ажил хийгдээгүй тул энэхүү ажилтай холбоотойгоор усны нөөц хомсдох эрсдэл үүсээгүй болно.

УДБҮ-ийн төслийн талбайн бэлтгэл ажлаас газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн доорх хүснэгтэд тусгасан ажлуудыг 2022 онд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-6: Газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Хог хаягдлыг ил задгай хаях, шатах тослох материалын бохирдол хур борооны усаар нэвчин газрын доорх усыг бохирдуулах	Төслийн талбайд нэвтрэх машин, механизмын техникийн бүрэн байдлыг шалгаж, баталгаажуулсны дараа талбайд нэвтрүүлэх	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна (Зураг 4-4-аас харна уу.)	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэх тул зардал гараагүй.
2		Төслийн талбайд машин, механизмд засвар хийхийг хориглох ба зайлшгүй тохиолдолд жижиг хэмжээний засвар хийх шаардлага үүсэх тохиолдолд хөрсөнд асгаралт шингээгч алчуур дэвсэж, асгаралтаас сэргийлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй бөгөөд техникийн тосны асгаралт үүсээгүй болно.	-
3		Асгаралт шингээгч иж бүрдлийг төслийн талбайд байрлуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайд түр оффисын зүүн талд асгаралт шингээгч иж бүрдэл	Асгаралт шингээгч иж бүрдлийн зардал нь газрын гадарга, хэвлийг

				байрлуулж, бэлэн байдлыг хангасан (Зураг 4-3-оос харна уу.)	хамгаалах хэсэгт тусгагдсан.	
4		Төслийн талбайд шинээр гаргах гүний худгаас сард 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх	Төслийн талбайн гүний худаг	Төлөвлөж байгаа	Төслийн талбайд гүний худгийг 2022 оны 11-р сард багтаан гаргахаар төлөвлөж байна. Гүний худаг гаргасны дараа тус худгаас сард 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх ажлыг гүйцэтгэх болно.	-
5		Онцгой байдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулан ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн “Онцгой байдлын менежментийн төлөвлөгөө”-г 2022 оны 10-р сард багтаан боловсруулж, захиалагчаар хянуулахаар төлөвлөж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулах тул зардал гараагүй.
6		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсдад сургалтаар дамжуулан олгосон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай агуулгыг тусгасан ба 2022 оны 10-р сарын байдлаар нийт 130 ажилтанд 41 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгааны сургалт олгосон байна (4.1 хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулах тул зардал гараагүй.
7		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан оновчтой хэрэгжүүлэх; Ил задгай хог хаяхгүй байх ба өдөр бүрийн ажил дууссаны дараа талбайн цэвэрлэгээг тогтмол хийх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. Өдөр бүрийн талбайн ажил дууссаны дараа ажлын байрны эмх цэгцийг хангуулах ажлыг төслийн барилга угсралтын баг болон талбайн супервайзор хариуцан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна (Зураг 4.10-аас харна уу).	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулах тул зардал гараагүй.

					“Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1г-ээс дэлгэрэнгүй харна уу.	
8		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх, мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Хог хаягдлыг ангилан ялгах агуулгыг төслийн урьдчилсан зааварчилгаанд оруулж, нийт ажилчдад мэдээлэл хүргэн ажиллаж байна (4.1 хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулах тул зардал гараагүй.
9	Бохир ус цуглуулах танкнаас асгаралт үүсэж хөрсөнд нэвчин газрын доорх усыг бохирдуулах	Төслийн талбайд бохир ус цуглуулах танк худалдан авч, суурилуулах. Тухайн танкийг үйлдвэрлэгчээс хүлээн авахдаа битүүмжийн тест хийлгүүлж, баталгаажуулж авах (битүүмж болон үл эвдэх сорилоор баталгаажсан агааржуулалт бүхий танк байх)	Төслийн талбайн бохир ус цуглуулах танк	Бүрэн хэрэгжсэн	Гүйцэтгэгчийн түр оффис болон инженерийн түр оффист зориулан 20 тонны 2 ш бохир ус цуглуулах танкийг төслийн талбайд суурилуулсан бөгөөд тус танкийг суурилуулахын өмнө “Үл эвдэх сорилын хяналт” болон “Шингэн нэвчүүлэх сорил” хийлгэж, баталгаажуулсан (Зураг 4.11, Зураг 4.12 болон Хавсралт 3-аас нэмэлт мэдээлэлтэй танилцана уу).	15,000,000
10		Бохир усны танканд хуримтлагдсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар тогтмол давтамжтай соруулах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бохир усыг соруулах ажил үйлчилгээний гэрээг “Ус сувгийн удирдах газар”-тай байгуулсан (Хавсралт 4-т гэрээний хуулбарыг хавсаргав). Тайлант хугацаанд 2 удаагийн нийт 20 тн бохир ус соруулах ажил гүйцэтгэгдсэн (Зураг 4-13).	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө хэсгийн зардалд тусгагдсан.
11	Газрын доорх усыг ашигласнаар ашигласан хэмжээгээр	Цооног өрөмдөх, худаг гаргах зөвшөөрөл авах ба төслийн талбайд ашиглах хугацыг паспортжуулах	Төслийн талбайн гүний худаг	Төлөвлөж байгаа	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан төслийн талбайд гүний	-

12	гүний усны нөөц багасах, усны хэрэглээний хяналтыг хэрэгжүүлээгүйн улмаас ус ашиглах дүгнэлтэд зааснаас илүү хэмжээний ус ашиглах эрсдэл үүсэж болзошгүй	Харьяа эрх бүхий төрийн байгууллагаас ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах зөвшөөрөл авах ба ус ашиглах гэрээнд заасны дагуу ус ашиглалтын төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөх	Төслийн талбайн гүний худаг	Төлөвлөж байгаа	худаг гаргах ажил 2022 оны 11-р сард хийгдэхээр хойшилсон ба 10-р сарын байдлаар тус ажлыг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. Туслан гүйцэтгэгч сонгогдсоны дараа	-
13		Ус ашиглах дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	Төслийн талбайн гүний худаг	Төлөвлөж байгаа	<ul style="list-style-type: none"> • Цооног өрөмдөх, гүний худаг гаргах зөвшөөрөл • Ус ашиглалтын зөвшөөрөл • Ус ашиглалтын гэрээ байгуулж, төлбөр төлөх зэрэг ажлуудыг гүйцэтгэж эхлэхээр төлөвлөж байна.	-
14		Усны гаралт дээр усны тоолуур суурилуулж, усны зарцуулалтад тогтмол хяналт тавих	Төслийн талбайн гүний худаг	Төлөвлөж байгаа		-
15		Худгийн тоолуур хэвийн ажиллах боломжийг бүрдүүлж, худгийг тоноглох буюу халаагуур тавих	Төслийн талбайн гүний худаг	Төлөвлөж байгаа		-
16		Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Усны нөөц болон чанарын менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1д-ээс дэлгэрэнгүй харна уу	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулах тул зардал гараагүй.

17		Ариун цэврийн өрөөний усны зарцуулалтыг хэмнэх зорилгоор түр оффист автомат холигч цорго суурилуулах	Түр оффисын ариун цэврийн өрөөний нийт цорго	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн түр оффисын ариун цэврийн өрөөнүүдэд автомат холигч цорго суурилуулсан (Зураг 4-14).	600,000 (12 ш * 50,000₮)
18		Гүйцэтгэгчийн “Ногоон дүрэм”-ийн дагуу ус хэмнэх дадал, арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсад сургалтаар дамжуулан олгосон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжиж байна	Ногоон дүрмийн мэдээлэл болон хэвшүүлэх дадлын талаарх уриалгыг төслийн урьдчилсан зааварчилгаанд оруулан нийт ажилчдад мэдээлэл түгээж байна (Тус биелэлтийн тайлангийн 4.1 хэсгээс сургалтын хэсэгтэй танилцана уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулах тул зардал гараагүй.
19	Ундны усны чанар алдагдах	Төслийн ундны усыг ойролцоох эрүүл ахуйн шаардлага хангасан худгаас зөөвөрлөх ба тухайн худгаас жилд 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх	Ундны ус зөөвөрлөх гүний худаг	Төлөвлөж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед ажилчдын ундны усыг “Галшинт ХХК”-ны 18.9 литрийн баллон бүхий цэвэр усаар хангаж байгаа тул дээж авах шаардлагагүй болсон бөгөөд тус ажлыг төслийн талбайн гал тогооны үйл ажиллагаа эхэлсний дараа ундны усны 10 тн бүхий савнаас дээж аван хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	-
20		Ундны ус нөөцлөх савыг улиралд 1 удаа цэвэрлэн халдваргүйжүүлэлт хийх, цэвэрлэгээний бүртгэл хөтөлж, баримтжуулсан байх	Ундны ус нөөцлүүр сав	Бүрэн хэрэгжсэн	Ундны усны 10 тн бүхий нөөцийн савыг мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэн, цэвэрлүүлж ашиглахад бэлэн болгосон (Зураг 4-15 болон Хавсралт 5-аас дэлгэрэнгүй мэдээллийг харна уу).	140,000
21		Ундны ус нөөцлөх савнаас улиралд 1 удаа усны дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх	Ундны ус нөөцлүүр сав	Төлөвлөж байна	Ундны ус нөөцлөх савыг ашиглаж эхлээгүй байгаа бөгөөд төслийн талбайн гал тогооны үйл ажиллагаа эхэлсний дараа ундны усны дээж авч шинжлүүлэхээр төлөвлөж байна.	-
					Нийт	15,740,000

Зураг 4-11 Гүйцэтгэгчийн түр оффисын бохир цуглуулах танк болон танк суурилуулж буй байдал, 2022.08.16



Зураг 4-12 Инженерийн түр оффисын бохир цуглуулах танканд шингэн нэвчүүлэх сорил хийж буй болон танк суурилуулж буй байдал, 2022.10.13




Зураг 4-13 УСУГ-ын зориулалтын тээврийн хэрэгслээр бохир ус соруулж буй байдал



Зураг 4-14 Түүр оффист автомат цорго болон 2 сонголттой суултуур суурилуулсан байдал



Зураг 4-15 Ундны усны танк цэвэрлэж буй байдал



4.8 Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн барилга байгууламж барих талбай өнгөн хөрсгүй тул өнгөн хөрс хуулалтын ажил хийгдэхгүй, мөн 2022 онд Толгойт дэд станцаас УДБҮ хүртэлх цахилгаан дамжуулах шугамыг барих ажил явагдахгүй юм. Тиймээс, 2022 онд хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд ШТМ-ын асгаралт болон хог хаягдлын менежментийг зөв зохистой хийх шаардлагатай тул хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах 17 бүлэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-7: Хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Машин, механизмуудаас ШТМ гоожсон тохиолдолд тухайн орчмын талбайн хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй	УДБҮ-ийн төслийн талбайд хэрэгжүүлэх “Хөрс хамгаалах төлөвлөгөө” боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-нд асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө тусгагдан боловсруулагдсан. Тус төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1е-ээс дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.
2		Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-нд энэхүү ажлын холбогдох шаардлагууд тусгагдсан. Тус төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан,	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.

		ажиллах ба энэхүү төлөвлөгөө нь бохир усны хаягдал, асгаралтын менежмент, хатуу болон аюултай хог хаягдлын менежмент зэргийг зохицуулсан төлөвлөгөө байна.			батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Хөрс хамгаалах менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1е-ээс дэлгэрэнгүй харна уу.	
3		Төслийн талбайд нэвтрэх машин, механизмын техникийн бүрэн байдлыг шалгаж, баталгаажуулсны дараа талбайд нэвтрүүлэх	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэж буй тул зардал гараагүй.
4		Төслийн талбайд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн техникийн бүрэн байдал (тос масло, ШТМ-ын асгаралт үүсгэдэггүй байх, яндангаас гарах утааны түвшин хэвийн байх г.м)-д сар бүр үзлэг шалгалт хийх ба үл тохирол илэрсэн тохиолдолд залруулах арга хэмжээ авах зааварчилгааг холбогдох талд өгч, хэрэгжилтийг хангуулах	УДБҮ-ийн төслийн талбайн нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна (Зураг 4-4-өөс харна уу). Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг гүйцэтгэж буй тул зардал гараагүй.
5		Төслийн талбайд машин, механизмд засвар хийхийг хориглох ба зайлшгүй тохиолдолд жижиг хэмжээний засвар хийх шаардлага үүсэх тохиолдолд хөрсөнд асгаралт шингээгч	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй бөгөөд техникийн тосны асгаралт үүсээгүй болно.	-

		алчуур дэвсэж, асгаралтаас сэргийлэх				
6		Төслийн талбайд тээврийн хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэхийг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед машин техник, тоног төхөөрөмжийн шатахуун цэнэглэлтийг төслийн талбайд гүйцэтгээгүй бөгөөд ойролцоох шатахуун түгээх станцаас цэнэглэж, шатахууны бэлэн байдлыг хангасны дараа төслийн талбайд техник, тоног төхөөрөмжийг оруулж, ажил гүйцэтгэхийг сануулан шаардлага тавьж ажилласан. Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
7		Их, бага аль ч хэмжээний ШТМ-ын асгаралт үүсгэж буй техникийн хэрэгсэлд төслийн багаас хяналт тавьж, үл тохирлыг арилгах арга хэмжээг авах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй бөгөөд техникийн тосны асгаралт үүсээгүй болно.	-
8		Төслийн талбайгаас гарах хүнд машин механизмын дугуйг угааж, цэвэрлэхээс бусад тохиолдолд төслийн талбайд машин механизм угаахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед талбайд машин механизм угаасан зөрчил гараагүй.	-
9		Асгаралт шингээгч иж бүрдлийг төслийн талбайд байрлуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайд асгаралт шингээгч иж бүрдлийг түр оффисын зүүн талд байрлуулж бэлэн байдлыг хангасан (Зураг 4-3-аас харна уу).	Газрын гадарга, хэвлийг хамгаалах хэсэгт тусгагдсан.

10		Асгаралт үүсэж хуулсан хөрс, асгаралтыг шингээсэн шингээгч материал зэргийн хаягдлыг аюултай хог хаягдлын хэсэгт хаях	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байна	Тайлант хугацаанд асгаралт үүссэн ямар нэг зөрчил гараагүй боловч Шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын үеэс үүсэж үлдсэн техникийн тосны асгаралтуудыг цэвэрлэх ажил 2022 оны 11-р сард багтан хийгдэхээр төлөвлөгдөж байна. Иймд, тус ажлын үед хуулагдсан хөрсийг аюултай хог хаягдлын хэсэгт цуглуулж, аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч устгалд оруулах ажил хийгдэнэ.	-
11		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсадад сургалтаар дамжуулан олгосон байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай агуулгыг тусгасан ба 2022 оны 10-р сарын байдлаар нийт 130 ажилтанд 41 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгааны сургалт олгосон байна (4.1 хэсгээс дэлгэрэнгүй харна уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.
12	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяснаас хөрсөн бүрхэвч бохирдох	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.

					Хавсралт 1г-ээс дэлгэрэнгүй харна уу.	
13		Төслийн талбайд нэгдсэн хогийн цэг байгуулах ба хог хаягдлыг ангилан хаях хэсэгтэй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед Зураг 8-2-оос Зураг 8-4-г үзүүлсэн хогийн цэгийг төслийн талбайд бий болгон ажилласан ба хог хаягдлыг аюултай, төмөр, мод, хуванцар, цаас, бусад гэсэн төрөлд ангилан хаясан.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.
14		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх, мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Хог хаягдлыг ангилан ялгах агуулгыг төслийн урьдчилсан зааварчилгаанд оруулж, нийт ажилчдад мэдээлэл хүргэн ажиллаж байна (Тус биелэлтийн тайлангийн 4.1 хэсгээс дэлгэрэнгүй харна уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.
15		Хог хаягдал тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тээвэрлүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд үүссэн ахуйн болон барилгын дахин боловсруулах боломжгүй бусад хог хаягдлыг 2022 оны 8-р сарын 18-ны өдөр “Улаантоором констракшн ХХК”-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу зөөж тээвэрлүүлэн Улаанчулуут хогийн цэгт устгалд оруулсан.	1,496,000 (16 удаагийн ачилт * 93,500₮)
16		Дахивар хаягдлыг ангилан ялгаж, дахивар хүлээн авах цэг болон байгууллагуудад хүлээлгэн өгөх	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн талбайд дахивар хаягдлыг ангилан цуглуулж байгаа бөгөөд 2022 оны 10-р сарын байдлаар ойролцоогоор 5 кг хуванцар савны дахивар цугларсан байна. Иймд, төслийн талбайн дахивар хаягдлыг тээвэрлэх тодорхой хэмжээнд хүрсний дараа хоёрдогч түүхий эд авдаг “Төвшин сайхан төв”-д	-

					хүлээлгэж өгөхөөр төлөвлөж байна (Зураг 8-3).	
17		Төслийн талбайд үүссэн будаг, цемент гэх мэт аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг аюултай хог хаягдлын тустай цэгт хаях ба химийн бодисын хаягдал устгах эрх бүхий байгууллагад шилжүүлж устгалд оруулах	УДБҮ-ийн төслийн талбай, аюултай хог хаягдал	Төлөвлөж байгаа	Төслийн талбайд хуримтлагдсан барилгын материалын сав баглаа боодлын аюултай хаягдлыг хөрсөнд асгаралт үүсгэхгүй төмөр хогийн саванд цуглуулж байна. Аюултай хаягдлыг тээвэрлэх тодорхой хэмжээнд хүрсний дараа аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэн устгалд оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд аюултай хог хаягдал устгах эрх бүхий байгууллагатай ажил үйлчилгээний гэрээ байгуулахаар худалдан авалтын үе шат үргэлжилж байна.	-
					Нийт	1,496,000

4.9 Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн талбай нь ШТЦБ-ийн барилгын ажлын нөлөөлөлд аль хэдийн өртөж, байгалийн унаган төрхөө алдсан тул барилгажих талбайгаас хуулах өнгөн хөрс, ургамлан нөмрөг байхгүй (БОННУ, Эко Трейд ХХК). Мөн 2022 онд Толгойт дэд станцаас УДБҮ хүртэлх цахилгаан дамжуулах шугамыг барих ажил хийгдээгүй тул тус онд төслийн бэлтгэл ажлын хүрээнд ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байгаагүй болно.

УДБҮ барих талбайд ШТЦБ-ын барилгын суурийн хөрсийг овоолго үүсгэн байршуулсан ба түүний эргэн тойронд хөл газрын ургамал ургасан. Эдгээр ургамлууд нь харшил үүсгэх чадвартай тул төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд эдгээр ургамлуудыг цэвэрлэх, төслийн талбайг тэгшилж бэлтгэх ажлыг 4,000 м² талбайд зохион байгуулсан (Зураг 4-16).

Зураг 4-16 Хөл газрын ургамлыг цэвэрлэхээс өмнө болон цэвэрлэсний дараах зураг



4.10 Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу тус онд Толгойт дэд станцаас УДБҮ хүртэлх цахилгаан дамжуулах шугамыг барих ажил хийгдээгүй ч барилгын угсралтын түр цахилгааны ажлын хүрээнд хэрэглэгдэх 400кВА-ын түр цахилгаан дэд станцын угсралтын ажил хийгдсэн. Тус түр цахилгааны дэд станцын тэжээлийн кабелийг төслийн талбайн хойно байрлах “Түмэн төмөрт” ХХК-ны хашаан дахь өндөр хүчдэлийн 10кВ-ын №21-р тулгуураас газраар 50 метр бүрээстэй кабель утсаар төслийн талбай руу тэжээл татах ажил хийгдсэн. Тус ажлын хүрээнд MNS 6518:2015 0.4 кВ-аас 22 кВ-ын хүчдэлийн агаарын шугам. Барьж байгуулахад тавигдах шаардлага стандартын шаардлагын дагуу шувуу хамгаалах зорилгоор шинээр сольж суулгасан өндөр хүчдэлийн агаарын шугамын №21-р тулгуурт 2 ш шувуу үргээгч угсарч суурилуулсан (Зураг 4-17).



4.11 Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Төслийн талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй. Тиймээс энэ төслийн үйл ажиллагаанаас тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй болно (БОННУ, Эко Трейд ХХК).

4.12 Дуу шуугиан, доргио чичиргээнээс үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Эко Трейд ХХК-ны гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-нд УДБҮ-ийн төслийн талбайг дараах байдлаар тодорхойлсон.

- Дуу шуугианд хамгийн их өртөгчид бол барилгын ажилчид, төслийн талбайд ойр байрлах аж ахуйн нэгжүүд байна. Дуу шуугианы голомтод эрчим нь 93 дБ хүрэх боломжтой тул дуу шуугианы тархалтын нөлөөгөөр амьтад, тухайлбал мэрэгч, шувууд дайжих эрсдэлтэй боловч төслийн талбай нь олон төрлийн шувууд, ховор болон нэн ховор амьтдын амьдрах орчин биш юм. Харин одоо байгаа мэрэгч, зарим төрлийн шувууд нь хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд аль хэдийн өртсөн, тухайн орчиндоо дасан зохицох чадвартай болсон. Эдгээр амьтад нөлөөлөлд өртөж, дайжих тохиолдол гарсан ч барилгажилтын үе богино тул эргэн суурьших боломжтой.

Тиймээс 2022 онд дуу шуугианаас нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд барилгын ажилчид болон УДБҮ-ийн төслийн талбайн шууд нөлөөллийн бүсэд байрлах аж ахуйн нэгжүүдийг анхаарч дараах 6 бүлэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4-8: Дуу шуугианаас нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Ажилчид болон УДБҮ барих талбай орчмын иргэд, аж ахуйн нэгжүүд ашиглагдах машин техник, барилгын үйл ажиллагаанаас ялгарах дуу шуугианы сөрөг нөлөөлөлд өртөх	УДБҮ-ийн төслийн хүрээнд дуу шуугиан болон доргио чичиргээний менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн “Агаарын чанар болон дуу чимээний менежментийн төлөвлөгөө”-г боловсруулсан. Тухайн төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна. “Агаарын чанар болон дуу чимээний менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1б-ээс дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй.
2	Ажилчдын шуугианы даралтын эквивалент түвшин 80 дБ болон үүнээс өндөр шуугианы нөлөөлөлд байх тохиолдолд сонсгол хамгаалах хэрэгсэл буюу чихний бөглөө заавал хэрэглүүлэх	Ажилчдын шуугианы даралтын эквивалент түвшин 80 дБ болон үүнээс өндөр шуугианы нөлөөлөлд байх тохиолдолд сонсгол хамгаалах хэрэгсэл буюу чихний бөглөө заавал хэрэглүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	80 дБ болон үүнээс өндөр шуугианы нөлөөлөлд өртөх тохиолдолд хэрэглэх 200 ш чихний бөглөөний бэлэн байдлыг хангаж төслийн талбайд байршуулсан (Зураг 4-18).	132,000 (200 ш * 660₮)
3	Төслийн талбайд дуу шуугианы хэмжилтийг зөөврийн хэмжигч төхөөрөмжөөр өдөр бүр хийж, баримтжуулах	Төслийн талбайд дуу шуугианы хэмжилтийг зөөврийн хэмжигч төхөөрөмжөөр өдөр бүр хийж, баримтжуулах	УДБҮ-ийн төслийн талбай болон нөлөөллийн бүсийн ойр орчим	Тогтмол хэрэгжүүлж байна	Зөөврийн дуу чимээ хэмжигч худалдан авсан ба өдөр бүр дуу чимээний хэмжилтийг хийж, төслийн өдрийн тайланд мэдээллийг оруулан ажиллаж байна (Зураг 4-19).	1,540,000 (Зөөврийн дуу чимээ хэмжигч багаж)

					Дуу чимээний хэмжилтийн 2022 оны 10-р сарын бүртгэлийн нэгтгэлийг Хавсралт 6-аас үзнэ үү.	
4		Туслан гүйцэтгэгчдийн хөдөлгүүрийн яндангийн дуу чимээ ихтэй хүнд машин механизмуудад тохирох дуу намсгагч суурилуулахыг шаардах ба хэрэгжилтийг хангуулах (Ажил гүйцэтгэх гэрээнд шаардлагыг тусгасан байх)	УДБҮ-ийн төслийн талбайд ашиглах хөдөлгүүрийн яндангийн дуу чимээ ихтэй хүнд машин механизм	Тогтмол хэрэгжүүлж байна	Ажил гүйцэтгэх гэрээнд холбогдох шаардлагыг тусгасан ба тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
5		Гомдол гарсан тохиолдолд GRM-гомдол барагдуулах механизм (Бүдүүвч 2)-ын дагуу шийдвэрлэх ба GRM-ийн талаарх мэдээллийг нийт ажилтан, нөлөөллийн бүсийн ААН болон бүхий л оролцогч талуудад нээлттэй байлгах	УДБҮ-ийн төслийн талбай, оролцогч талууд	Тогтмол хэрэгжүүлж байна	Гомдол хүлээн авах сувгуудын мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаанд багтаасан ба нийт ажилчдад мэдээлэл хүргэж ажиллаж байна. Мөн төслийн хэмжээнд санал, гомдол хүлээн авах утсыг 24/7 цагийн турш ажиллуулж байна. Тайлант хугацаанд байгаль орчны асуудлаар санал, гомдол бүртгэгдээгүй байна.	GRM-гомдол барагдуулах механизмын хэвийн ажиллагаатай холбоотой үүсэх зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
6		Дуу чимээ, доргио чичиргээний өртөлт болон тэдгээрийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан нийт ажилтнуудад мэдээлэх, сонсгол хамгаалах хэрэгслийн хэрэглээг идэвхжүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн урьдчилсан зааварчилгаанд дуу чимээ, чичиргээний үед ашиглах хувийн хамгаалах хэрэгслийн мэдээлэл багтсан бөгөөд төслийн талбайд ХАБЭА-н ажилтан хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээнд хяналт, шаардлага тавин ажиллаж байна.	-
					Нийт	1,672,000

Зураг 4-18 Шаардлагатай тохиолдолд чихний бөглөөгөөр ханган ажиллаж байна



Зураг 4-19 Төслийн талбайд хэмжилт хийж буй зөөврийн дуу чимээ хэмжигч багаж



4.13 Цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал уснаас гарах үнэрээс нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

УДБҮ-ийн төслийн талбай нь төв цэвэрлэх байгууламжийн баруун талд байрладаг бөгөөд төслийн талбай орчмоос хүхэрт устөрөгч (H_2S)-ийн үнэр үнэртдэг. Энэхүү хийн эх үүсвэр ТЦБ-ын одоогийн ашиглаж байгаа лаг хатаах талбай юм. Хүхэрт устөрөгч нь өнгөгүй, муудсан өндөгтэй төстэй үнэртэй, агаараас 1.19 дахин хүнд, маш хортой, идэмхий, шатамхай, тэсрэмтгий хий бөгөөд агаараас хүнд учир агааржуулалт муутай орчны ёроолд хуримтлагдах хандлагатай байна. Тиймээс, ТЦБ-ын лаг хатаах талбайгаас ялгарч буй уг хий нь УДБҮ-ийн төслийн барилгажилтын явцад төслийн ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй тул төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд дараах 5 бүлэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4-9: ТЦБ-ын лаг хатаах талбайгаас гарах хүхэрт устөрөгчөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг

1		УДБҮ-ийн төслийн хүрээнд үнэрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн талбайн ажилчдын түр оффис ашиглалтад орсны дараа “Ажлын байрны нөхцөлийн үнэлгээ”-г мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр ажиллаж байгаа ба тухайн үнэлгээний үр дүн болон зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	-
2	Төслийн талбайд үнэртдэг хүхэрт устөрөгч нь төслийн нийт ажилчдын эрүүл мэнд, ажиллах орчинд сөргөөр нөлөөлөх	Төслийн талбайд өдөр бүр зөөврийн багажаар хүхэрт устөрөгчийн хэмжилтийг хийж, 2ppm-ээс давсан тохиолдолд нийт ажилтнуудад мэдээлдэг байх. Мэдээлэл дамжуулах хэлбэр нь өглөөний цугларалт/pre-start meeting, viber, мэдээлэх самбар дээрх H ₂ S үзүүлэлтийн хэмжээ гэх мэт.	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд хүхэрт устөрөгчийн хэмжилтийг зөөврийн багажаар болон итгэмжлэгдсэн лабораториор хэмжүүлсэн ба 2 ppm давсан тохиолдол илрээгүй (Лабораторийн хэмжилтийн хариуг тус биелэлтийн тайлангийн 9.1 хэсгээс харна уу).	3,000,000 (Агаарын найрлага хэмжигч зөөврийн багаж)
3		Төслийн талбайд ашиглах шүүлтүүртэй маскийн бэлэн байдлыг хангах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Ковид-19 цар тахлаас сэргийлэх үүднээс амны хаалтыг төслийн талбайд тогтмол байршуулж, нөөцөөр ханган ажиллаж байна. Мөн үнэрийн менежментийн хүрээнд төслийн талбайд 10 ш шүүлтүүртэй маск худалдан авч, бэлэн байдлыг хангасан.	495,000 (10 ш * 49,500₮)
4		Хүхэрт устөрөгчийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нийт ажилтнуудад таниулах, мэдээлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	2022 оны 12-р сард багтаан тус мэдээллийг хүргэхээр төлөвлөж байна.	-
5		Оффист байрлах агааржуулагчийн шүүлтүүрийг улиралд 1 удаа тогтмол давтамжтай цэвэрлэдэг байх	УДБҮ-ийн төслийн талбайн оффис	Төлөвлөж байгаа	2022 оны 10-р сарын байдлаар төслийн талбайн түр оффис ашиглалтад ороогүй байгаа тул энэхүү ажил хийгдээгүй байна.	-
						Нийт

4.14 Нийгэм эдийн засагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүснэгт 4-10: Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн “Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө”-г 2022 оны 10-р сард багтаан боловсруулж, захиалагчаар хянуулахаар төлөвлөж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зардал нь төслийн ХАБЭА-н зардалд багтана.
2		Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, захиалагчаар хянуулсан ба 2022.09.19-ны өдөр батлагдсан. “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1ж-оос дэлгэрэнгүй харна уу.	Гүйцэтгэгчийн төслийн баг боловсруулж буй тул зардал гараагүй. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
3		Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн нийт оролцогч талуудыг тодорхойлж, тухайн оролцогч талуудтай хэрхэн харилцах тухай “Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө”-г боловсруулсан. Тухайн төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба захиалагчийн хяналтын явц үргэлжилж байна.	Гүйцэтгэгчийн төслийн баг боловсруулж буй тул зардал гараагүй. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.

4		Жендер ба нийгмийн оролцооны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн “Жендер ба нийгмийн оролцооны төлөвлөгөө”-г боловсруулсан. Тухайн төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна.	Гүйцэтгэгчийн жендер ба нийгмийн баг боловсруулж буй тул зардал гараагүй. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
5	Жендерийн тэгш байдал ба жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамт	Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн “Хүний нөөцийн менежментийн төлөвлөгөө”-г боловсруулсан. Тухайн төлөвлөгөөг төслийн захиалагчаар хянуулан, батлуулахаар хүргүүлсэн ба хяналтын явц үргэлжилж байна.	
6		Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын төлөвлөгөө”-г боловсруулж, захиалагчаар хянуулсан ба 2022.10.13-ны өдөр батлагдсан. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зардал нь төслийн ХАБЭА-н зардалд багтана.
7		Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын төлөвлөгөө”-г боловсруулж, захиалагчаар хянуулсан ба 2022.10.13-ны өдөр батлагдсан. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	
8	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал	Онцгой байдлын бэлэн байдал болон хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Төлөвлөж байгаа	Төслийн “Онцгой байдлын бэлэн байдал болон хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулах явц үргэлжилж байгаа ба 2022 оны 10-р сард багтаан төслийн захиалагчид хүргүүлж, хянуулахаар төлөвлөж байна.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг боловсруулж буй тул зардал гараагүй. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах зардал нь төслийн ХАБЭА-н зардалд багтана.
					Нийт	-

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ус дахин боловсруулах үйлдвэр (УДБҮ)-ийн төслийн талбай нь Шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын нөлөөлөлд аль хэдийн өртөж, байгалийн унаган төрхөө алдсан ба барилгажих талбайгаас хуулах өнгөн хөрс, ургамлан нөмрөг байхгүй талбайд баригдана.

УДБҮ-ийн төслийн барилга угсралтын ажлын дараах орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж эхлэх хугацаа 2024 оны 5-р сараас эхэлж байгаа тул 2022 онд УДБҮ-ийн төслийн хүрээнд орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ямар нэгэн ажил хийгдээгүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан төслийн нийт ажилчдад санамсаргүй байдлаар түүх дурсгалын үнэт өв илрүүлсэн тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний мэдээллийг хүргэн ажиллаж байна (Тус биелэлтийн тайлангийн 4.1 хэсгээс харна уу). Тайлант хугацаанд төслийн талбайгаас ямар нэг палеонтологи болон археологийн олдвор илрээгүй.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УДБҮ-ийн төслийн түр байгууламж байгуулах ажлын үед шатанд тохиолдож болзошгүй осол, аюул, эрсдэлүүдийг урьдчилан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсөн бөгөөд тухайн төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтэд нэгтгэн харуулсан ба баримтжуулсан мэдээллийг Зураг 7-2-т үзүүлэв.

Хүснэгт 7-1: УДБҮ-ийн төслийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Барилгын үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж барилгын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Удирдлагын баг; ХАБЭА-н баг	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн бэлтгэл ажлын хугацаанд төслийн ХАБЭАБО-ны баг хөдөлмөр хамгааллын аюулгүй байдалд өдөр бүр хяналт тавин, төслийн ХАБЭА-н төлөвлөгөөг хэрэгжүүлэн, үл тохирол үүсэхээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Зураг 7-2-оос харна уу.	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хэрэгжилтийг хангуулж ажиллаж байгаа ба холбогдох зардал нь төслийн ХАБЭА-н зардалд багтана.
2		Хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах	БУ-ын баг; ХАБЭА-н баг	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭАБО-ны баг нь талбайн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хяналтыг өдөр бүр гүйцэтгэдэг бөгөөд тус хяналтаар хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянаж ажиллаж байна. Төслийн талбайд хэрэгждэг хувийн хамгаалах хэрэгслийн шаардлагыг Зураг 7-1-ээс харна уу.	
3		Нийт ажиллагсад компанийн “Алтан дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллах	Төслийн нийт ажилчид	Тогтмол хэрэгжүүлж байна	Алтан дүрмийн мэдээллийг төслийн урьдчилсан зааварчилгаанд оруулан нийт ажилчдад мэдээлэл түгээж байгаа бөгөөд өдөр тутамд	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж

					дагаж мөрдөхийг уриалан ажиллаж байна. Алтан дүрмийн мэдээллийг Зураг 7-3-аас харна уу.	байгаа тул зардал гараагүй.
4		Төслийн талбайд шинээр ирж буй ажилтныг төслийн урьдчилсан зааварчилгаанд заавал хамруулах ба өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэх ажилтнуудыг өндөр эрсдэлийн сургалтад хамруулснаар төслийн талбайд ажил хийх эрх олгох; Нийт ажилтны ХАБЭА-н сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах	Нийт ажилчид; өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэх нийт ажилчид	Тогтмол хэрэгжүүлж байна	2022 оны 10-р сарын байдлаар нийтдээ 130 ажилтан 41 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгаанд хамрагдсан (Зураг 4-2, Зураг 7-2 а болон Зураг 7-2 б). Өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэх нийт 124 ажилтанд өндөр эрсдэлтэй ажлын сургалт орсон ба дараах төрлүүдээр сургалт орсон байна (Зураг 4-2). Үүнд: <ul style="list-style-type: none"> • Өндөрт ажиллах зааварчилгаа – 31 ажилтан • Өргөлтийн ажлын зааварчилгаа – 12 ажилтан • Газар шорооны ажлын зааварчилгаа – 29 ажилтан • Өндөр хэмийн ажлын зааварчилгаа – 52 ажилтан 	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хэрэгжилтийг хангуулж ажиллаж байгаа тул зардал гараагүй.
5		Төслийн талбайд ашиглах машин, механизмын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, баримтжуулсан байх	УДБҮ-ийн төслийн талбайд ашиглах машин, механизм тээврийн хэрэгслүүд	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгсэл тус бүрд төслийн ХАБЭАБО-ны баг тээврийн хэрэгслийн шалгах хуудас ашиглан хяналт шалгалт хийж баталгаажуулсны дараа тухайн тээврийн хэрэгслийг төслийн талбайд нэвтрүүлэх эрх олгон ажиллаж байна. Мөн тухайн тээврийн хэрэгсэл техникийн	Гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг хэрэгжилтийг хангуулж ажиллаж байгаа тул зардал гараагүй.

					хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх шаардлагатай ба тухайн шаардлагын хэрэгжилтэд төслийн ХАБЭАБО-ны баг хяналт тавин, баталгаажуулан ажиллаж байна (Зураг 4-4).	
6		Зохих стандартын шаардлага хангасан хайс, хашлага, замын тэмдэг, тэмдэглэгээг шаардлагатай гэж үзсэн газруудад байрлуулах	УДБҮ-ийн төслийн барилгажилтын талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭА-н баг нь төслийн талбайд үүссэн ил нүх, аюул бүхий хэсгүүдэд тухай бүр хатуу хаалт хашилт болон анхааруулах мэдээллийн хуудас байрлуулан аюулгүй байдлыг ханган ажиллаж байна (Зураг 7-2 з). Мөн төслийн талбайд зохих замын тэмдгүүд байршуулсан (Зураг 7-2 з).	1,683,000 (17 тэмдэг * 99,000₮)
7		Төслийн талбайд тамхи татах тусгай цэг төлөвлөх ба бусад зөвшөөрөгдөөгүй газар тамхи татахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд тамхи татах тусгай цэгийг Инженер оффисын зүүн талд (Зураг 7-2 д) болон гүйцэтгэгчийн контейнер оффисын урд (Зураг 7-2 и) байршуулан, тэмдэгжүүлсэн.	100,000
8	Гал түймэр	Аливаа халуун боловсруулалтын ажлыг галын харуул болон гал унтраагуур байрлуулан гүйцэтгэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн ХАБЭА-н баг хэрэгжилтийг тогтмол хангуулан ажиллаж байна.	-
9		Стандартын шаардлагын дагуу гал унтраах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нийт 20 ш галын хорыг байршуулсан бөгөөд галын хорын ашиглалтын бэлэн байдалд төслийн ХАБЭА-н баг хяналт тавин ажиллаж байна (Зураг 7-2 е).	1,320,000 (20 ш * 66,000₮)

10		Төслийн талбайд хог шатаах болон ил задгай гал гаргахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
11	Химийн бодисын асгаралт үүсэх	Химийн бодисын асгаралт шингээх иж бүрдэл төслийн талбайд байрлуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайд асгаралт шингээгч иж бүрдэл байрлуулсан (Зураг 4-3).	Газрын гадарга, хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.
12		Төслийн талбайд нэвтрэх химийн бодис бүр ХАЛМ-тэй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд нэвтрэх химийн бодисуудын ХАЛМ-ын хураангуй тайланг бэлтгэн, холбогдох ажилчдад танилцуулан ажиллаж байна. ХАЛМ-ын хураангуй тайлангийн загварыг Хавсралт 7-оос харна уу.	-
13		Химийн бодистой харьцах, асгаралтаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг олгох сургалтыг төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан нийт ажилтанд олгох	УДБҮ-ийн төслийн нийт ажилчид	Тогтмол хэрэгжүүлж байна	Химийн бодистой харьцах, асгаралтаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах мэдлэг олгох сургалтыг төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад тусгасан (Тус биелэлтийн тайлангийн 4.1 хэсгээс дэлгэрэнгүй харна уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.
14	Тээврийн хэрэгслийн осол	Төслийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах ба төслийн талбайд хурдны дээд хязгаарыг 10 км/ц-аас хэтрүүлэхгүй байх	УДБҮ-ийн төслийн талбайд нэвтрэх нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө” батлагдсан бөгөөд талбайд холбогдох тэмдэг, тэмдэглээг байршуулан, хурдны хязгаарт хяналт тавин ажиллаж байна. “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1ж-ээс дэлгэрэнгүй харна уу.	Газрын гадарга, хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэсэгт тусгагдсан.

15		Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг баримталж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбайд нэвтрэх нийт тээврийн хэрэгсэл	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө” батлагдсан бөгөөд жолооч нарт тавигдах шаардлагыг ажил үйлчилгээний гэрээнд тусгаж, шаардлага тавин ажиллаж байна. “Замын хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө”-ний агуулгыг Хавсралт 1ж-ээс дэлгэрэнгүй харна уу.	-
16	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс /ган, үер/ төслийн талбайн	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн талбайн бэлтгэл ажлын явцад тогтмол ашиглах	Улаанбаатар хот, УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Шаардлагатай тохиолдолд төслийн талбайн ажлыг урьдчилан төлөвлөхөд ашиглаж байна.	-
17	үйл ажиллагаа доголдох, зогсох	Үерийн усны шуудуу татах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн бэлтгэл ажлын хугацаанд Зураг 7-2 й - д үзүүлсэн үерийн усны шуудуу татсан.	-
18	Халдварт өвчин тархах (Ковид-19 халдварын тархалт дахин дэгдэх)	Ковид-19 халдвараас сэргийлж KN95/ N95/ P2 төрлийн амны хаалт зүүх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд амны хаалтын бэлэн байдлыг тогтмол хангаж ажиллаж байна (Зураг 7-2 к).	Гүйцэтгэгчийн төслийн ХАБЭА-н зардалд багтана.
19		Оффисын орчинд гар ариутгагч байршуулах ба гар угаах саванг ариун цэврийн өрөөнд байршуулж, ажилчдын гар угаах боломжийг бүрдүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Ариун цэврийн өрөөнүүдэд гар угаах хэрэгслийн бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна (Зураг 7-2 л).	
20		Хүн хоорондын зайг 1.5 м-ээс багагүй байлгах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн бэлтгэл ажлын хугацаанд Ковид-19 халдварт өвчний батлагдсан тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд өглөө бүр төслийн талбайн харуул ажилтнуудын биеийн халууны хэмжилтийг хэмжин нэвтрүүлж байна (Зураг 7-2 н).	
21		Өглөө бүр ажилчдын халууныг хэмжсэний дараа ажлын байранд нэвтрүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна		

22	Ковид-19 халдварт өвчний түргэн оношлуурын бэлэн байдлыг хангах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд Ковид-19 халдварт өвчний түргэн оношлуурын бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна (Зураг 7-2 м).	
23	Ковид-19 эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Ковид-19 эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг төслийн “Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын төлөвлөгөө”-ний 6.6.10 хэсэгт тусгасан бөгөөд тус төлөвлөгөө нь 2022.10.13-ны өдөр батлагдсан. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	
				Нийт	3,103,000

Зураг 7-1 Төслийн талбайд хэрэгждэг хувийн хамгаалах хэрэгслийн шаардлага



5. ХАБЭАБО-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

ХАБЭАБО-НЫ УРЬДЧИЛСАН ХЯНАЛТ
Хувийн хамгаалах хэрэгсэл




- Эрүүвчилсэн дуулга
- Нүдний хамгаалалтын шил
- Урт ханцуйтай цамц, хантааз
- Бээлий
- Гэрэл ойлгогчтой өмд
- Ажлын гутал

- MNS ISO 13688:2000 Стандартын шаардлага хангасан ажлын хувцсыг хэрэглэхийг зөвшөөрнө.
- Ажлын хувцасны жигдрэлийг хангасан байх ба компанийн нэр, лого зургийг ажлын хувцсанд багтаасан байна
- Өндрийн бүс, хамгаалалтын малгай, хамгаалалтын гутлыг “Хамгаалах хэрэгслийн баталгаажуулалтын лаборатори”-оор туршилт хийлгэж баталгаажуулсан байна.
- Химийн бодистой харьцах ажилтны хувийн хамгаалах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг ХАЛМ-д заасны дагуу хангасан байна.

Зураг 7-2 Төслийн талбайд осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлж буй байдал




Зураг 7-2 а



Зураг 7-2 б

Төслийн урьдчилсан зааварчилгаанд хамрагдаж буй ажиллагсад



Зураг 7-2 в

Өглөөний цугларалт



Зураг 7-2 г

Аюулгүй ажиллагааны хэлэлцүүлэг




Зураг 7-2 д

Төслийн талбайн тамхины цэг: Инженер оффисын зүүн талд



Зураг 7-2 е

Галын аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт



Зураг 7-2 ё

Ажлын зөвшөөрөл, аюулгүй ажиллагааны дүн шинжилгээ



Зураг 7-2 ж

Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ

Зураг 7-2 з



Төслийн талбайд аюул бүхий хэсгүүдийг тусгаарласан хатуу хаалт хашилт, анхааруулах мэдээлэл байршуулсан байдал болон замын тэмдэг байрлуулсан байдал

Зураг 7-2 и



Төслийн талбайн тамхины цэг: Гүйцэтгэгчийн контейнер оффисын урд

Зураг 7-2 й



Үерийн ус зайлуулах шуудуу гаргасан байдал: Инженер оффисын баруун талд

Зураг 7-2 к



Амны хаалтын бэлэн байдлыг хангасан байдал

Зураг 7-2 л



Ариун цэврийн өрөөнүүдэд гар угаах хэрэгсэл байршуулсан байдал

Зураг 7-2 м



Ковид-19 халдварт өвчний түргэн оношлуурын бэлэн байдлыг хангасан байдал

Зураг 7-2 н



Төслийн талбайн харуул ажилтнуудын биеийн халууныг хэмжиж буй байдал

Зураг 7-3 Төслийн талбайд хэрэгждэг хөдөлмөрийн аюулгүй байдлын “Алтан дүрэм”

MCSproperty

2. ХАБЭА-Н АЛТАН ДҮРЭМ

Ерөнхий гүйцэтгэгч нь Захиалагчийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааны үндэс болох Амь нас хамгаалах 6 дүрмийг хатуу мөрдөх бөгөөд, ажиллагчиддаа аюулгүй ажиллагааны зөв хандлага төлөвшүүлнэ. Энэ дүрэм төслийн оролцогч талуудын амь насыг хамгаалах, аюулгүй ажиллагааны гол шаардлага юм.

 Өргөгдсөн ачааны доор ажил гүйцэтгэхгүй байх	 Өндрийн түвшингийн зөрүү 1,5м –с их бол уналтаас хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ	 Ил задгай ирмэг дээр ажил гүйцэтгэхгүй ба хаалт хамаалт хийсэн байна
 Ажлын байран дээр мансууруулах бодисын нөлөөнд автаагүй байна	 Хязгаарлагдмал орчинд ажиллахдаа зөвшөөрөл авна	 Өндөр эрсдэлтэй ажлыг эрх бүхий зөвшөөрөлтэй хүн ажиллана

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УДБҮ-ийн төслийн талбайд хог хаягдлыг зохицуулахад нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх буй арга хэмжээ нь төслийн талбайд хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд ажилчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж хог хаягдлыг ангилан ялгах зан төлөвийг хэвшүүлэх явдал юм.

Энэхүү ажлын хүрээнд хог хаягдлыг ангилан хаях мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаагаар дамжуулан олгож байгаа ба 2022 оны 10-р сарын байдлаар нийт 130 ажилтанд 41 удаагийн урьдчилсан зааварчилгааны сургалтыг зохион байгуулжээ.

Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд контейнер оффист ахуйн хог хаягдлыг цаас, хуванцар, хаягдал зай хураагуур болон бусад гэсэн төрлүүдэд ангилан ялгаж байгаа бөгөөд ангилан ялгалтын талаарх мэдээллийг зурагт хуудас хэлбэр (Зураг 8-1)-ээр байршуулсан. Мөн тус хугацаанд барилгын хог хаягдлыг төмрийн хаягдал, модны хаягдал, аюултай хаягдал болон бусад хаягдал гэсэн төрлүүдэд ангилан хаяж буй бөгөөд ангилан ялгасан бусад төрлийн хаягдлыг тухай бүрд нь устгалд оруулан ажиллаж байна. Төслийн талбайн бэлтгэл ажлын цар хүрээнд хамааран төмөр, мод, аюултай хаягдал зэрэг нь холбогдох дахин боловсруулах болон аюултай хаягдал устгах байгууллагад шилжүүлэх хэмжээнд хүрээгүй байгаа тул төслийн талбайд цуглуулан түр хадгалж байна.

Зураг 8-1 Хог хаягдал ангилан ялгах заавар



2022 оны 8-р сараас 10-р сарын хооронд УДБҮ-ийн төслийн талбайн бэлтгэл ажлаас гарсан нийт хаягдлын хэмжээг Хүснэгт 8-1-ээр, хог хаягдлын төлөвлөгөөний биелэлтийг Хүснэгт 8-2-оор харуулав.

Хүснэгт 8-1 Нийт хог хаягдлын хэмжээ, 2022 оны 10-р сарын 25-ны байдлаар

№	Хог хаягдлын төрөл	Хэмжээ (2022.08-2022.10)	Тайлбар
Дахивар хаягдал			
1	Төслийн талбайд хуримтлагдсан хуванцар хаягдал	5 кг	Дахивар хаягдлыг төслийн талбайн ангилан ялгалтын хогийн цэгт цуглуулж байгаа ба тээвэрлэх тодорхой хэмжээнд хүрсний дараа “Төвшин Сайхан Төв” 2-догч түүхий эд авах цэгт нийлүүлэхээр төлөвлөж байна.
2	Төслийн талбайд хуримтлагдсан хаягдал цаас	0 кг	
Ахуйн шингэн хаягдал			
3	Шингэн хаягдал-ахуйн бохир ус	20 тн	Төслийн талбайн ахуйн бохир усыг 2022 оны 9-р сарын 14-ны өдөр “Ус сувгийн удирдах газар (УСУГ)”-тай байгуулсан аж ахуйн гэрээний дагуу төслийн талбайн бохир ус цуглуулах танкнаас соруулан УСУГ-ын тээврээр

			бохир ус нийлүүлэх цэг рүү тээвэрлүүлж байна.
Аюултай хаягдал			
4	Төслийн талбайд хуримтлагдсан барилгын материалын сав баглаа боодлын аюултай хаягдал	10 кг	Төслийн талбайд хуримтлагдсан барилгын материалын сав баглаа боодлын аюултай хаягдлыг хөрсөнд асгаралт үүсгэхгүй төмөр хогийн саванд цуглуулж байна. Аюултай хаягдлыг тээвэрлэх тодорхой хэмжээнд хүрсний дараа аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэн устгалд оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагыг сонгон шалгаруулж, ажил үйлчилгээний гэрээ байгуулах худалдан авалтын үе шат явагдаж байна. (Хог хаягдлын тухай хуульд зааснаар 1 сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол тухайн аюултай хаягдлыг эх үүсвэр дээр нь 180 хоног түр хадгалахыг зөвшөөрдөг байна)
5	Төслийн талбайд хуримтлагдсан хаягдал хуруу зай	0.2 кг	Хаягдал хуруу зай цуглуулах сав түр оффист байршуулсан бөгөөд улиралд 1 удаа Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоонд шилжүүлэн устгалд оруулахаар төлөвлөж байна.
Улаанчулуут хогийн цэгт устгалд оруулсан дахин боловсруулах боломжгүй хаягдал			
6	Ахуйн болон барилгын бусад хог хаягдал	16 тн	Төслийн талбайд үүссэн ахуйн болон барилгын дахин боловсруулах боломжгүй бусад хог хаягдлыг 2022 оны 8-р сарын 18-ны өдөр “Улаантоором констракшн ХХК”-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу зөөж тээвэрлүүлэн Улаанчулуут хогийн цэгт устгалд оруулсан. Хог хаягдлын бүртгэлийг Хавсралт-8-д хавсаргав.

Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд Зураг 8-2-ээс Зураг 8-4-т үзүүлсэн хог хаягдлын цэг болон хогийн савыг төслийн талбайд байршуулан ажиллаж буй бөгөөд УДБҮ-ийн төслийн үндсэн

барилгын ажил эхлэх хугацаа буюу 2023 онд Зураг 8-5 болон Зураг 8-6-д харуулсан нэгдсэн хогийн цэгийг төслийн талбайд бий болгон ажиллахаар төлөвлөж байна.

Зураг 8-2 Төслийн талбайн бэлтгэл ажлын хугацаанд талбайд байрцуулсан хогийн цэг




Зураг 8-3 Хуванцар хаягдал цуглуулдаг хогийн сав



Зураг 8-4 Түр оффисын хог хаягдал ангилан ялгалтын сав



Зураг 8-5 2023 онд төслийн талбайд бий болгохоор төлөвлөж буй барилгын хаягдлын нэгдсэн хогийн цэг (Зүүн талаас: Бусад хог, Мод, Төмөр, Аюултай хаягдал)



Зураг 8-6 2023 онд төслийн талбайд бий болгохоор төлөвлөж буй ахуйн хаягдлын нэгдсэн хогийн цэг (Зүүн талаас: Хүнсний хаягдал, Дахин боловсруулах хаягдал, Бусад хаягдал)



2022 онд УДБУ-ийн төслийн хүрээнд хог хаягдлын менежменттэй холбоотой доорх 13 бүлэг ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 8-2: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Хэрэгжилт	Зарцуулагдсан төсөв, төг
1	Ахуйн хатуу хог хаягдал	Түр оффисын хүрээнд хаягдлыг бичгийн цаас, хуванцар, хаягдал хуруу зай, бусад гэсэн 4-н төрөлд ангилан хаяж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн түр оффисын хүрээнд цаас, хуванцар, хаягдал зай, бусад гэсэн 4-н төрлийн ангилан ялгалтын хогийн сав байрлуулан, дахивар хаягдлыг цуглуулж байна (Зураг 8-4).	1,308,000 (4 хос ангилан ялгалтын сав * 327,000₮)
2	Ахуйн шингэн хаягдал	Төслийн талбайд 20 тн багтаамжтай бохир ус цуглуулах танк байршуулж, бохир усыг хуримтлуулах ба тогтмол давтамжтай тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар соруулах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд 20 тн багтаамжтай бохир ус цуглуулах танк (Зураг 4-11 болон Зураг 4-12) байршуулж бохир усыг хуримтлуулж байгаа ба УСҮГ-тай бохир ус соруулах ажил үйлчилгээний гэрээ байгуулан тогтмол давтамжтай соруулж байна. Хавсралт 3-т УСҮГ-тай байгуулсан гэрээг хавсаргав. Тайлант хугацаанд нийт 20 тн бохир ус соруулсан бөгөөд бохир ус соруулах үеийн баримтжуулсан мэдээллийг Зураг 4-13-аас харна уу.	104,560 (2 удаагийн бохир соруулалт * 52,280₮)
3	Ахуйн шингэн хаягдал	Ахуйн бохир усны хэмжээг багасгах зорилгоор түр оффист автомат холигч цорго суурилуулах	УДБҮ-ийн төслийн талбай	Бүрэн хэрэгжсэн	Төслийн талбайн түр оффисын ариун цэврийн өрөөнүүдэд автомат холигч цорго суурилуулсан (Зураг 4-14).	Газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэсэгт тусгагдсан.

4		Төслийн талбайд нэгдсэн хогийн цэг байгуулах ба хог хаягдлыг ангилан хаях хэсэгтэй байх	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед түр ашиглах зориулалттай хогийн цэг байгуулж ажилласан (Зураг 8-2 болон 8-3). Цаашид үндсэн барилгын ажлын үед ашиглах ангилан ялгалтын хогийн цэг байгуулах ажлыг хэрэгжүүлэхээр худалдан авалтын үе шатанд шилжүүлэн ажиллаж байна (Зураг 8-5 болон 8-6).	940,000 (2 ш хогийн сав * 470,000₮)
5	Үйлдвэрийн буюу барилгын хаягдал	Барилгын хаягдлыг хог хаягдал зөөж, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан, устгалд оруулах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Барилгын талбайн бэлтгэл ажлын хүрээнд “Улаантоором констракшн ХХК”-тай барилгын талбайн хог хаягдал цэвэрлэх, зөөж тээвэрлэх ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Тус байгууллага нь хог хаягдлыг тээвэрлэн Улаанчулуут хогийн цэгт шилжүүлэн ажиллаж байна.	Хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэсэгт тусгагдсан.
6		Барилгын хог хаягдлыг мод, төмөр, аюултай хаягдал, бусад гэсэн 4 төрөлд ангилан хаях ба дахин ашиглах.	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	2022 оны 8-р сараас эхлэн төслийн талбайн бэлтгэл ажил эхэлсэн бөгөөд ажлын цар хүрээнээс хамааран дахин боловсруулах, дахин ашиглах боломжтой хаягдал үүсээгүй байна.	-
7	Аюултай хог хаягдал	Төслийн талбайд үүссэн будаг, цемент гэх мэт аливаа химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг аюултай хог хаягдлын тустай цэгт хаях ба химийн бодисын хаягдал устгах эрх бүхий байгууллагад шилжүүлж устгалд оруулах	УДБҮ-ийн төслийн талбай, аюултай хог хаягдал	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд будаг, шахдаг хөөсний сав зэрэг химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг хөрсөнд асгаралт үүсгэхгүй тустай хогийн саванд цуглуулж байна. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай ажил үйлчилгээний гэрээ байгуулсны дараа цугларсан химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг тус байгууллагад шилжүүлэн	-

					устгахаар төлөвлөж байгаа ба аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулах худалдан авалтын үе шат явагдаж байна.	
8	Ерөнхий арга хэмжээ	Талбайн өдөр бүрийн ажлын дараа талбай цэвэрлэх журам/заавар боловсруулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Талбайн өдөр бүрийн ажлын дараа талбайг цэвэрлэж, эмх цэгцийг хангуулан ажиллаж байна (Зураг 4-10).	-
9		Төслийн талбайд нийт ажилчдад зориулсан ариун цэврийн байгууламжийг шийдэх ба бохирын гаргалгааг төслийн талбай дах бохир ус цуглуулах танктай холбох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд нийт ажилчдад зориулсан ариун цэврийн байгууламжийг бий болгож (Зураг 8-7), бохир усыг бохир ус цуглуулах танканд цуглуулж байна.	Ажилчдын ариун цэврийн өрөө шийдэх ажлын зардал нь төслийн үйл ажиллагааны зардалд багтана.
10		Нийт ажиллагчдыг хог хаягдлыг ангилан хаях дадалд хэвшүүлэх мэдлэгийг төслийн урьдчилсан зааварчилгаа болон зурагт хуудсаар дамжуулан олгох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Хог хаягдлыг ангилан ялгах агуулгыг төслийн урьдчилсан зааварчилгаанд оруулж, нийт 130 ажилчдад мэдээлэл хүргэн ажиллаж байна (Тус биелэлтийн тайлангийн 4.1 хэсгээс дэлгэрэнгүй харна уу).	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.
11		Төслийн талбайд хог хаягдал шатаахыг хориглох	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй.	-
12		Аливаа асгаралт үүссэн тохиолдолд захиалагч талд мэдэгдэх ба онц байдал үүссэн тохиолдолд ОБЕГ болон түргэн тусламж дуудах	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Тайлант хугацаанд ямар нэг зөрчил гараагүй бөгөөд химийн бараа материалын болон техникийн тос зэрэг аливаа асгаралт үүсээгүй болно.	-
13		Асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай мэдлэгийг төслийн нийт ажиллагсдад	УДБҮ-ийн төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн урьдчилсан зааварчилгааны агуулгад асгаралтаас сэргийлэх болон асгаралт үүссэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай агуулгыг тусгасан ба 2022	Сургалтыг гүйцэтгэгчийн ХАБЭАБО-ны баг зохион байгуулж буй тул зардал гараагүй.

		сургалтаар дамжуулан олгосон байх			оны 10-р сарын байдлаар нийт 130 ажилтанд 41 удаагийн төслийн урьдчилсан зааварчилгааны сургалт олгосон байна (Тус биелэлтийн тайлангийн 4.1 хэсгээс дэлгэрэнгүй харна уу).	
					Нийт	2,352,560

Зураг 8-7 Төслийн талбайн бэлтгэл ажлын үед ашиглаж буй нийт ажилчдад зориулсан ариун цэврийн байгууламж



9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

9.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Эко трейд ХХК-ны гүйцэтгэсэн БОННУ-нд тусгаснаар агаарын чанарт нөлөөлөх үндсэн эх үүсвэр нь төслийн талбайд ашиглагдах машин, техникүүд байх ба машин, техникүүдийн хөдөлгөөнөөс тоосонцор (PM_{2.5} болон PM₁₀), хөдөлгүүрээс бохирдуулагч хийнүүд (SO₂, NO₂) агаар мандалд тархаж, агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй гэж тодорхойлсон. Эдгээрийн агаарын чанарт үзүүлэх нөлөө, цаашлаад агаарын чанарын холбогдох стандарт шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянахын тулд УДБҮ-ийн төслийн талбайд БОННУ-нд заасан байршилд “Ногоон титэм ХХК”-аар агаарын чанарын хэмжилт хийлгэж хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 9-1: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй агаарын чанарын хяналт шинжилгээ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Тайлбар
PM ₁₀ , PM _{2.5} , Тоосонцор	УДБҮ-ийн талбай N47°54' 01.3'' E106°45'06''	1 сард 1 удаа; Шаардлагатай тохиолдолд нэмэлт давтамжаар хэмжилт хийх	2 байршилд тус бүр 5 удаа	Тогтмол хэрэгжүүлж байна	Хэмжилтийг 10-р сараас эхлэн итгэмжлэгдсэн лабораториор хэмжүүлж байгаа бөгөөд 10-р сарын хэмжилтийн үр дүнг Хавсралт 4-д хавсаргав.
CO, NO, NO ₂ , SO ₂ , H ₂ S	УДБҮ-ийн талбай N47°54' 01.3'' E106°45'06''	1 сард 1 удаа; Шаардлагатай тохиолдолд давтамжийг нэмэх	2 байршилд тус бүр 5 удаа	Тогтмол хэрэгжүүлж байна	Хэмжилтийг 9-р сараас эхлэн итгэмжлэгдсэн лабораториор хэмжүүлж байна. 9-р сарын хэмжилтийн үр дүнгийн дэлгэрэнгүйг Хүснэгт 8-2-оос, 10-р сарын хэмжилтийн үр дүнг Хүснэгт 8-3-аас харна уу.

“Ногоон титэм ХХК”-ийн лабораторийн сорилтын тайланд тусгаснаар 2022 оны 9-р сарын шинжилгээний хариу Монгол улсын холбогдох стандартын зөвшөөрөгдөх түвшин давсан үзүүлэлт бүртгэгдээгүй буюу MNS 4585:2016 болон MNS 5885:2008 стандартуудын шаардлагад нийцэж байв. 2022 оны 10-р сард хийгдсэн агаарын чанарын шинжилгээний үр дүнгээс үзэхэд PM₁₀ тоосонцрын хэмжээ стандартын зөвшөөрөгдөх түвшнээс 5.47 мкг/м³-аар давсан үзүүлэлттэй байгаа бол бусад бүх үзүүлэлт нь MNS 4585:2016 стандартуудын шаардлагад нийцэж байна.

Агаарын чанарын хяналт шинжилгээний үеийн баримтжуулсан мэдээллийг Зураг 9-1 болон 9-2-оос, итгэмжлэгдсэн лабораторийн хэмжилтийн баталгаажуулсан тайланг Хавсралт 9-өөс дэлгэрэнгүй танилцана уу.

Хүснэгт 9-2 2022.09.30-ны өдрийн агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн тайлан

Тодорхойлох үзүүлэлт	Сорилтын аргын стандарт	Сорилтын дүн, хэмжих нэгж	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	Байршил
Азотын давхар исэл NO ₂	MNS ISO 6768:2005	33.10 мкг/м ³	200 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
Хүхэрлэг хий SO ₂	ISO 6767:1990	391.30 мкг/м ³	450 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
Нүүрстөрөгчийн дугуу исэл CO	MNS 4991:2000	<1 ppm	60,000 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
Тодорхойлох үзүүлэлт	Сорилтын аргын стандарт	Сорилтын дүн, хэмжих нэгж	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага	Байршил
Хүхэрт устөрөгч H ₂ S	MNS 4991:2000	0.00 мкг/м ³	10 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн түр оффисын урд (N47°54'7.3728 E106°44' 56.58)

Хүснэгт 9-3 2022.10.20-ны өдрийн агаарын чанарын хэмжилтийн үр дүнгийн тайлан

Тодорхойлох үзүүлэлт	Сорилтын аргын стандарт	Сорилтын дүн, хэмжих нэгж	MNS 4585:2016	Байршил
Азотын давхар исэл NO ₂	MNS ISO 6768:2005	9.30 мкг/м ³	200 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
Хүхэрлэг хий SO ₂	ISO 6767:1990	40.95 мкг/м ³	450 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
Нүүрстөрөгчийн дугуу исэл CO	MNS 4991:2000	<1 ppm	60,000 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд

				(N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
PM _{2.5} тоосонцор	MNS 6657:2017	<1 мкг/м ³	50 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')
PM ₁₀ тоосонцор	MNS 6656:2017	105.47 мкг/м ³	100 мкг/м ³	УДБҮ-ийн төслийн талбайн зүүн урд (N47°54' 0.522'' E106°45'4.0536'')

Зураг 9-1 Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал 2022.09.30



*NO₂, SO₂, CO-ийн хэмжилт



* H₂S-ийн хэмжилт

Зураг 9-2 Агаарын чанарын хяналт шинжилгээний хэмжилт хийж буй байдал 2022.10.20



* PM₁₀, PM_{2.5}, NO₂, SO₂, CO-ийн хэмжилт



9.2 Дуу шуугианы хяналт шинжилгээ

Эко трейд ХХК-ны хийсэн судалгаагаар орчны дуу шуугианы бохирдлын хэмжээ 72-75 дБ буюу MNS 4585:2016 стандартаас 12-15 дБ-ээр болон Дэлхийн Банкны үйлдвэржсэн районд тавигддаг стандартаас их байсан нь төсөл хэрэгжих талбай дуу шуугианы бохирдолд өртсөн байгааг илтгэнэ. МУ-ын дуу шуугианы бохирдлын өдрийн хугацааны зөвшөөрөгдөх хэмжээ 60 дБ (MNS 4585:2016) байдаг бол Дэлхийн Банкны стандартаар 70 дБ, дуу чимээтэй газар ажиллаж байгаа хүнд хүрэх долгионы хэмжээ 85 дБ байна. Иймд, УДБҮ-ийн төслийн талбайн дуу шуугианы түвшин нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор дуу шуугианы хяналт шинжилгээг явуулан, Монгол улсын Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тус хяналт шинжилгээг дуу шуугианы хэмжилтийн PCE-EM883 зөөврийн багажаар төслийн талбайн 2 цэгт өдөр бүр хэмжилт хийж, төслийн өдрийн тайланд оруулан захиалагчид мэдээлж байна. Дуу чимээний хэмжилтийн 2022 оны 10-р сарын хэмжилтийн бүртгэлийг Хавсралт 6-д хавсаргасан ба хэмжилтийн дундаж үзүүлэлт 42.9 дБ байгаа ба MNS 4585:2016 стандартын шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 9-4: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй дуу шуугианы хяналт шинжилгээ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Тайлбар
Дуу шуугиан	УДБҮ-ийн талбай (N47°54' 01.3'' E106°45'06'', төслийн талбайн бэлтгэл ажлын ойр орчимд 1 цэг буюу нийт хамгийн багадаа 2 цэгт)	1 сард 1 удаа; Шаардлагатай тохиолдолд нэмэлт давтамжаар хэмжилт хийх	2 байршилд тус бүр 5 удаа	-	Агаарын чанарын хэмжилт хийж буй итгэмжлэгдсэн лаборатори дуу чимээний хэмжилт хийх боломжгүй гэсэн тул дуу шуугианы хэмжилтийг төслийн талбайд өдөр бүр зөөврийн багаж ашиглан хэмжилт хийж байна.
Дуу шуугиан	УДБҮ-ийн талбай (N47°54' 01.3'' E106°45'06'', төслийн талбайн бэлтгэл ажлын ойр орчимд 1 цэг буюу нийт хамгийн багадаа 2 цэгт)	Төсөл хэрэгжих хугацаанд тогтмол	Тогтмол, өдөрт 2 удаа (Шаардлагатай тохиолдолд давтамжийг нэмэх)	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайд өдөр бүр зөөврийн багаж ашиглан хэмжилт хийж байна.



9.3 Усны чанарын хяналт шинжилгээ

УДБҮ-ийн төслийн газрын доорх усны түвшин гадаргатай ойр тул аливаа их хэмжээний бохирдуулагч бодисын алдрал, ялангуяа шингэн төлөвт байгаа шатах тослох материал хөрсийг бохирдуулснаар газрын доорх ус бохирдох үндэс болох ба их хэмжээний бороо орсон тохиолдолд бохирдох эрсдэлийн эрчим нэмэгдэнэ. Тиймээс, төслийн үйл ажиллагаанаас усны чанарт үзүүлэх нөлөө, мөн усны чанар нь холбогдох стандарт шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянахын тулд УДБҮ-ийн төслийн талбайн дараах байршлуудад мэргэжлийн байгууллагаар сард 1 удаа усны хяналт шинжилгээг тогтмол хийлгэхээр төлөвлөсөн билээ. Гэвч төслийн талбайн бэлтгэл ажлын явц хойшлогдсонтой холбоотой 2022 оны 10-р сарын байдлаар төслийн талбайд цооног өрөмдөх, худаг гаргах ажил хийгдээгүй байгаа бөгөөд тус ажлыг гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах худалдан авалтын шат үргэлжилж байна. Иймд, 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан шинээр гаргах гүний худгийн усны чанарын хяналт шинжилгээ нь худаг гаргах хүртэл түр хугацаагаар хойшилж байна.

2022 оны төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд газрын доорх ус буюу хөрсний усыг шавхах ажил хийгдэхгүй тул төслийн талбайн бэлтгэл ажлаас гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй. Иймд, 2022 оны орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөнд гадаргын усны чанарын хяналт шинжилгээг төлөвлөөгүй болно.

2022 онд УДБҮ-ийн төслийн хэрэгжүүлэх усны чанарын хяналт шинжилгээг хүснэгт 9-5-т үзүүлэв.

Хүснэгт 9-5: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй усны чанарын хяналт шинжилгээ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Тайлбар
Газрын доорх усны чанар	Төслийн талбайд шинээр	1 сард 1 удаа	1 байршилд 9-р сараас 12-р сар	Төлөвлөж байгаа	2022 оны 10-р сарын байдлаар төслийн талбайд гүний худаг гаргах ажил хийгдээгүй байгаа

(Хими, хүнд металл, бактери)	гаргах гүний худаг		хүртэл нийт 4 удаа		тул энэхүү ажил нь худаг гаргах хүртэл хойшилж байна.
	Ундны ус зөөх гүний худаг, Ундны усны нөөцийн сав	1 сард 1 удаа	2 байршилд 11-р сараас 12-р сар хүртэл нийт 4 удаа	Төлөвлөж байгаа	Төслийн талбайн бэлтгэл ажлын үед ажилчдын ундны усыг “Галшинт ХХК”-ны 18.9 литрийн баллон бүхий цэвэр усаар хангаж байгаа тул шинжилгээ хийх шаардлагагүй. Төслийн түр оффис ашиглалтад орж гал тогооны үйл ажиллагаа эхэлсний дараа ундны усны 10 тн нөөцийн савнаас дээж авч шинжлүүлэхээр төлөвлөж байна.

9.4 Хөрсний хяналт шинжилгээ

УДБҮ-ийн барилга байгууламж барих талбайн хөрсний морфологи бүтэц, шинж чанар өөрчлөгдсөн антрисол хөрс зонхилон тархсан. Мөн ХУДБ төслийн хүрээнд Эко Трейд ХХК-ийн 2021 онд гүйцэтгэсэн судалгаагаар хөрсөн дэх 8 элемент (As, B, Cd, Cr, Cu, Mo, Pb, Zn)-ийн агууламж нь Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй гарсан (Эко Трейд ХХК, 2021). УДБҮ-ийн барилгажилтын үйл ажиллагааны үр дүнд хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжид гарч болох өөрчлөлт, мөн түүнчлэн хөрсний чанар нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор Хүснэгт 9-6-д тусгагдсан хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 9-6: УДБҮ-ийн төслийн 2022 онд хэрэгжүүлж буй хөрсний хяналт шинжилгээ

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжиг-дэхүүний нэгж	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж тоо	Хэрэгжилт (Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа)	Тайлбар
Хөрсөн дэх хүнд металлууд (As, B, Cd, Co, Cr, Cu, Hg, Mo, Ni, Pb, Sr, V, Zn)-ын агууламжийг тодорхойлох	хэмжих нэгж мг/кг	УДБҮ-ийн талбай (хогийн цэгийн ойр, бохир усны танкны ойр, машин зогсоолын ойр)	6 сард 1 удаа	3 байршилд тус бүр 1 удаа	Тогтмол хэрэгжүүлж байна	2022.09.30-ны өдөр төслийн талбайн 3 цэгээс (хогийн цэгийн ойр, бохир усны танкны ойр, машин зогсоолын ойр) хөрсний дээжийг MNS 3298:1990 стандартын шаардлагын дагуу авч, Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид хүргүүлж, шинжлүүлсэн. 9-р сарын хэмжилтийн үр дүнгийн дэлгэрэнгүйг Хүснэгт 9-7 болон 9-8-оос харна уу.

Хөрсөнд микробиологийн агууламжийг тодорхойлох	Нийт нянгийн тоо, ГБЭТ нян, Е-коли, Өвчин үүсгэгч бичил биетэн	УДБҮ-ийн талбай (хогийн цэгийн ойр, бохир усны танкны ойр, машин зогсоолын ойр)	6 сард 1 удаа	3 байршилд тус бүр 1 удаа	Төлөвлөж байгаа	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори нь хөрсөнд микробиологийн агууламжийг тодорхойлох боломжгүй гэсэн тул 12-р сард багтаан боломжит итгэмжлэгдсэн лабораториор тус үзүүлэлтийг шинжлүүлэхээр төлөвлөж байна.
--	--	---	---------------	---------------------------	-----------------	--

2022 оны 9-р сарын 30-ны өдөр шинжлүүлсэн хөрсний дээжийн сорилтын тайланд тусгаснаар Монгол улсын холбогдох стандартын зөвшөөрөгдөх түвшин давсан үзүүлэлт бүртгэгдээгүй бөгөөд MNS 5850:2008 стандартын шаардлагад нийцэж байв. Хөрсний чанарын хяналт шинжилгээний үеийн баримтжуулсан мэдээллийг Зураг 9-4-оос, итгэмжлэгдсэн лабораторийн үр дүнгийн тайланг Хавсралт 10-аас үзнэ үү.

Хүснэгт 9-7 Хөрсний чанарын хэмжилтийн хүнд металлын агууламжийн тайлан

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
		мг/кг							
1	Төслийн талбайн авто машины зогсоолын ойр	<0.005	11.2	<0.005	<0.005	71.4	29.3	17.0	311.5
2	Талбайн бохир ус цуглуулах танкны ойр	<0.005	12.5	<0.005	53.2	85.5	30.0	12.3	303.4
3	Талбайн хогийн цэгийн ойр	<0.005	13.0	<0.005	55.9	65.9	30.7	10.4	312.0
MNS 5850:2019 / ЗДХ/		3	100	2	150	300	100	50	800

Хүснэгт 9-8 Хөрсний чанарын хэмжилтийн агрохимийн үр дүнгийн тайлан

№	Сорьц авсан цэг	Чийг %	pH	Ялзмаг %	Аммоны азот (NH ₄ -N) мг/кг	Нитратын азот (NO ₃ -N) мг/кг	Фосфор (P ₂ O ₅) мг/кг	Сульфат (SO ₄) мг/кг
1	Төслийн талбайн авто машины зогсоолын ойр	2.21	7.92	0.14	37.0	4.5	49.2	16.6
2	Талбайн бохир ус цуглуулах танкны ойр	0.56	7.53	0.65	33.0	7.7	100.8	273.6
3	Талбайн хогийн цэгийн ойр	0.57	7.47	0.45	40.4	9.2	117.3	566.6

Зураг 9-4 Хөрсний чанарын хяналт шинжилгээний дээж авч буй байдал 2022.09.30



10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 10-1 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн огноо	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Гүний худгийн цооног өрөмдүүлэх ажлын хүрээнд холбогдох зөвшөөрлийг авч, худгийг паспортжуулах, ус ашиглах гэрээ байгуулах	2022 оны 10-р сарын байдлаар гүний худаг гаргах ажил эхлэхгүй байгаа бөгөөд цооног өрөмдөх, гүний худаг гаргах ажил гүйцэтгэх туслан гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд явж байна. Туслан гүйцэтгэгч сонгогдсоны дараа холбогдох зөвшөөрлүүдийг бүрдүүлэн ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.	-	Ж. Бат-Ирээдүй /Удирдах инженер/	Худгийн цооног өрөмдүүлэх ажлын өмнө холбогдох зөвшөөрлүүдийг авсан байх
2	Хог хаягдал зөөж, устгах зөвшөөрөл бүхий байгууллагатай ажил үйлчилгээний гэрээ байгуулах	Төслийн талбайгаас хог хаягдал зөөж тээвэрлэх, устгалд оруулах гэрээг төслийн талбайн бэлтгэл ажлын хүрээнд буюу 2023.01.01-ний өдөр хүртэл “Улаантоором констракшн ХХК”-тай байгуулсан ба Улаанчулуут хогийн	2022.08.18	О.Батзориг /Төслийн менежер/	

		цэгт устгалд оруулан ажиллаж байна.			
3	Бохир ус соруулах зөвшөөрөл бүхий байгууллагатай ажил үйлчилгээний гэрээ байгуулах	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах” аж ахуйн гэрээг “Ус сувгийн удирдах газар (УСУГ)”-тай байгуулсан.	2022.09.14	О.Батзориг /Төслийн менежер/	
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөвлөн, санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх, 50%-ийг тусгай дансанд байршуулах	Байгаль орчныг хамгаалах, хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож 16,422,000₮-ийг СХД.БО нөхөн сэргээх баталгааны 100200955402 төрийн сангийн дансанд байршуулсан. Шилжүүлгийн баримтыг Хавсралт 11-аас үзнэ үү.	2022.10.18	О.Батзориг /Төслийн менежер/	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ний төсөв 32,844,000₮ болж байгаа ба үүний 50%-ийг байршуулах шаардлагатай

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 11-1: Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах тайлагналын биелэлт

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнах, хэлэлцүүлэх оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулсан огноо	Тайлбар	Хариуцах эзэн
1	СХД-ийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны албанд	Танилцуулга, илтгэл болон тайлан гаргаж хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг байгаль орчны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Энэхүү ажлыг 2022 оны 12-р сард багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 12-р сарыг дуусах хүртэлх байгаль орчны ажлууд төлөвлөгдсөн тул тухайн ажлуудын гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлсний дараа буюу 12-р сард багтаан хэрэгжилтийн тайланг танилцуулахаар төлөвлөж байна.	ММСС, УДБҮ-ийн төслийн баг, Олон нийттэй харилцах баг
2	СХД-ийн 20-р хорооны иргэдэд	Хорооны иргэдийн төлөөллийг Хорооны байранд хүлээн авч, Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг байгаль орчны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Энэхүү ажлыг 2022 оны 12-р сард багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 12-р сарыг дуусах хүртэлх байгаль орчны ажлууд төлөвлөгдсөн тул тухайн ажлуудын гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлсний дараа буюу 12-р сард багтаан хэрэгжилтийн тайланг танилцуулахаар төлөвлөж байна.	ММСС, УДБҮ-ийн төслийн баг, Олон нийттэй харилцах баг

12. ДҮГНЭЛТ

УДБҮ-ийн төслийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орчны хяналт шинжилгээ хийх зэргээр нийт 132 ажил төлөвлөгдсөн ба 2022 оны 10-р сарын 25-ны өдрийн байдлаар төслийн гүйцэтгэгч нь төлөвлөгөөний биелэлтийг дараах гүйцэтгэлтэй ханган ажиллаж байна. Үүнд:

- Нийт 25 ажил буюу нийт төлөвлөгдсөн ажлын 18.9%-ийг бүрэн хэрэгжүүлсэн,
- Нийт 79 ажил буюу нийт төлөвлөгдсөн ажлын 59.8%-ийг тогтмол хэрэгжүүлж,
- Нийт 27 ажил буюу 20.5%-ийг 2022 оны 12-р сард багтаан хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Тус оны 12-р сард багтаан хийж гүйцэтгэх ажлын жагсаалтад дараах ажлууд хамаарах ба төслийн гүйцэтгэгч нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллах болно. Үүнд:

1. Төслийн талбайд гүний худгийг 2022 оны 11-р сард багтаан гаргаж, гүний худгийн уснаас сард 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх;
2. Төслийн “Онцгой байдлын менежментийн төлөвлөгөө”-г 2022 оны 10-р сард багтаан боловсруулж, захиалагчаар хянуулах;
3. Цооног өрөмдөх, худаг гаргах зөвшөөрөл авах ба төслийн талбайд ашиглах худгийг паспортжуулах;
4. Харьяа эрх бүхий төрийн байгууллагаас ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах зөвшөөрөл авах ба ус ашиглах гэрээнд заасны дагуу ус ашиглалтын төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөх;
5. Ус ашиглах дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх;
6. Усны гаралт дээр усны тоолуур суурилуулж, усны зарцуулалтад тогтмол хяналт тавих;
7. Худгийн тоолуур хэвийн ажиллах боломжийг бүрдүүлж, худгийг тоноглох буюу халаагуур тавих;
8. Ундны усны 10 тн бүхий савнаас улиралд 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх;
9. Төслийн ундны усыг ойролцоох эрүүл ахуйн шаардлага хангасан худгаас зөөвөрлөх ба тухайн худгаас жилд 1 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор хими, хүнд металл, бактерийн шинжилгээ хийлгүүлэх;
10. Шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын үеэс үүсэж үлдсэн техникийн тосны асгаралтуудыг цэвэрлэж, хуулсан хөрсийг аюултай хог хаягдлын хэсэгт цуглуулан эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч устгалд оруулах;
11. Цугларсан дахивар хаягдлыг дахивар хүлээн авах цэг болон байгууллагуудад хүлээлгэн өгөх;
12. Төслийн талбайд цугларсан аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдал устгах эрх бүхий байгууллагатай ажил үйлчилгээний гэрээ байгуулах;
13. Төслийн талбайн ажилчдын түр оффис ашиглалтад орсны дараа “Ажлын байрны нөхцөлийн үнэлгээ”-г мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

14. Хүхэрт устөрөгчийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нийт ажилтнуудад таниулах, мэдээлэх;
15. Оффист байрлах агааржуулагчийн шүүлтүүрийг улиралд 1 удаа тогтмол давтамжтай цэвэрлэдэг байх;
16. Төслийн “Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө”-г 2022 оны 10-р сард багтаан боловсруулж, захиалагчаар хянуулах;
17. Жендэрийн тэгш байдал ба жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх холбогдох төлөвлөгөөнүүдийг боловсруулан, төслийн захиалагчаар хянуулах;
18. Төслийн талбайн 3 байршлаас дээж авч, хөрсөнд микробиологийн агууламжийг тодорхойлох;
19. СХД-ийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны албанд БОМТ-ний хэрэгжилтийн явцыг байгаль орчны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах;
20. СХД-ийн 20-р хорооны иргэдэд 2022 оны БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах.

Тайлант хугацаанд төслийн талбайн бэлтгэл ажлаас үүдэлтэй байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсэн тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд төслийн гүйцэтгэгч нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахыг зорин ажиллаж байна.

-ооо-

**ХАВСРАЛТ 1. ГБОНМТ БОЛОН ТҮҮНИЙ ДЭД МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНҮҮДИЙН НҮҮР ХУУДАС**

Wastewater Recycling Plant

Contractor's Environmental and Social Management Plan

Document No.: **WRP-22-0015**

Revision: **rev01**

Date: **October 22, 2022**

Document Confirmation

Document name:	Contractor's Environmental and Social Management Plan (CESMP)
Total page:	59
Attachment number:	4
Prepared by:	Amgalanzaya G. /Gender and Social Inclusion Officer/ Khulan M. /Environmental Officer/
Reviewed by:	Bulgan A. /Gender and Social Inclusion Team Leader/ Tuvshintur T. /Health and Safety Team Leader/
Approved by:	Batzorig O. /Project Manager/

Change log Sheet

Revision	Date	Change reason
01	2022/10/22	First Submission

Table of Abbreviation

Abbreviation	Remark
AQNMP	Air Quality and Noise Management Plan
CESMP	Contractors Environmental and Social Management Plan
CESM	Contractors Environmental and Social Management
CEO	Chief Executive Officer of MCSP
CHPPs	Combined Heat and Power Plant
CSOs	Civil society organizations
C-TIP	Counter Trafficking in Persons
DP	Deputy Director of MCSP
DPAA	Direct Projected Affected Area
DWA	Downstream Wells Activity
EBRD	European Bank for Reconstruction and Development

Engineer	Program Management Consultant
Env	Environment
EPAA	Extended Project Affected Area
ESIA	Environmental and Social Impact Assessment
ESMP	Environmental and Social Management Plan
ESMS	Environmental and Social Management System
ITT	Indicator Tracking Table
IFC	International Finance Corporation
GBV	Gender Based Violence
GoM	Government of Mongolia
GRM	Grievance Redress Mechanism
GRO	Grievance officer
GSI	Gender and Social Inclusion
GSIT	Gender and Social Inclusion Team
GW	Ground Water
HRMP	Human Resource Management Plan
HRT	Human Resource Team
KPI	Key Performance Indicator
MBBR	Moving Bed Biofilm Reactor
MASM	Mongolian Agency for Standard Metrology
MCA-M	The Millenium Challenge Account- Mongolia
MCC	The Millenium Challenge Corporation
MCSP	MCS Property LLC
MOU	Memorandum of Understanding
MSDS	Material Safety Data Sheet
NGOs	Non-Governmental Organizations
NCWWTP	New Central Wastewater Treatment Plant

PAP	Projected Affected People
PMC	Program Management Consultant
PRS	Purchase requisition for service
PQQ	Pre-qualification questionnaire
RWTP	Recycled Water Transmission Pipelines
SMEs	Small and Medium Enterprises
SGIP	Social and Gender Integration Plan
TIP	Trafficking in Persons
TP	Training Plan
TVET	Technical and Vocational Education Training
TVETAC	Technical and Vocational Education Training Assessment Center
USUG	Ulaanbaatar Water Supply and Sewerage Authority
WRA	Wastewater Recycling Activity
WRP	Wastewater Recycling Plant
WSSA	Water Sector Sustainability Activity

CONTENTS

- 1. INTRODUCTION 6
 - 1.1 Project Director’s Commitment.....6
 - 1.2 Statutory Understanding and Compliance6
 - 1.3 Project Description.....14
 - 1.4 Baseline Studies21
 - 1.5 Environmental and Social Risks and Impacts.....31
 - 1.6 CESMP Objectives.....34
- 2. ROLES AND RESPONSIBILITIES 35
 - 2.1 Organization chart35
 - 2.2 Roles and Responsibilities.....35
- 3. CESMP IMPLEMENTATION SCHEDULE 37
- 4. ENVIRONMENTAL AND GENDER AND SOCIAL INCLUSION MANAGEMENT PROVISIONS 39
- 5. TRAINING..... 49
 - 5.1 Internal Training.....49
 - 5.2 External Training49
- 6. COMMUNICATIONS 50
 - 6.1 Communication with Subcontractors.....50
 - 6.2 External Communication.....50
 - 6.3 Grievance Redress Mechanism51
- 7. MONITORING 53
 - 7.1 KPI.....53
 - 7.2 Adaptive Management53
- 8. REPORTING 54
- 9. DOCUMENT CONTROL..... 55
 - 9.1 Document control55
 - 9.2 Document Management56
- REFERENCE 58

Wastewater Recycling Plant

Air Quality and Noise Management Plan

Document No.: **WRP-MCSP-ENV-AQNMP-001**

Revision: **01**

Date: **October 22, 2022**

Document Confirmation

Document name:	Air Quality and Noise Management Plan
Total page:	28
Attachment number:	2
Prepared by:	Khulan M. /Environmental Officer/
Reviewed by:	Tuvshintur T. /Health and Safety Team Lead/
Approved by:	Batzorig O. /Project Manager/

Change log Sheet

Revision	Date	Change reason
